



ФАТФ-ЫН ТАЙЛАН

# САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ

2012 оны 6 дугаар сар







## САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БҮЛЭГ

ФАТФ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх дэлхий нийтийн санхүүгийн системийг хамгаалах бодлого боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус бүлэг юм. ФАТФ-н зөвлөмж нь дэлхий нийтийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрөгдсөн.

ФАТФ-тай холбоотой нэмэлт мэдээллийг доорх цахим хуудаснаас авна уу.

[www.fatf-gafi.org](http://www.fatf-gafi.org)

Зөвлөмжийг ФАТФ-ын Тамгын газрын зөвшөөрлөөр  
Ж.Төгс-Очир орчуулав.

Хянасан: Шинжлэх ухааны доктор, профессор Ж.Болдбаатар  
Хууль зүйн магистр Б.Мөнхсэргэлэн

ISBN: 978-99978-0-698-7

© ФАТФ/ЭЗХАХБ. Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. 2012 он  
© AML/CFT Consulting Mongolia LLC. Орчуулах, хэвлэн нийтлэх эрх хуулиар  
хамгаалагдсан. 2017 он

“AML/CFT Consulting Mongolia LLC”-с урьдчилсан бичгээр зөвшөөрөл аваагүй  
тохиолдолд энэ хэвлэлийг хуулбарлах, орчуулахыг хориглоно.

Бүх болон хэсэгчилсэн хэвлэлтэй холбоотой зөвшөөрөл хүссэн өргөдлийг  
ФАТФ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт хүлээн авна.

2 Рью Андре Паскал 75775 Парис хот Цедекс 16, Франц Улс

(Факс: +33 1 44 30 61 37, и-мэйл: [contact@fatf-gafi.org](mailto:contact@fatf-gafi.org))

Хавтасны зураг: ©Thinkstock



“СУУРИЙН ЖАНЦАН САН”-н санхүүжилтээр хэвлэв.

[jantsanfoundation.mn](http://jantsanfoundation.mn)

2017 он

ДАА-345  
ННА-67.411  
Ф-27

## АГУУЛГА

<b>I. ЗӨВЛӨМЖИЙН ЗОРИЛГО</b> .....	3
Хууль сахиулах байгууллагатай холбогдох стандарт .....	5
Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зорилго, үр өгөөж .....	11
<b>II. САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ</b> .....	14
Мөрдөн шалгах ажиллагааны стратеги .....	14
Мөрдөн шалгах зэрэгцээ ажиллагаа .....	16
Хамтарсан ажлын хэсэг .....	20
Хөрөнгө нөхөн төлүүлэх ажиллагаа .....	23
Бүртгэл, мэдээлэл .....	25
<b>III. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ</b> .....	29
<b>IV. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ</b> .....	33
Мэдээллийн эх сурвалж, төрөл .....	34
<b>V. ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГА БОЛОН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА</b> .....	39
Санхүүгийн Мэдээллийн Алба ба мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааны мэдээллийг санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд ил болгох нь .....	39
Хууль сахиулах байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааны хүрээнд ил болгосон мэдээллийг ашиглах болон санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд Санхүүгийн Мэдээллийн Албаны дүн шинжилгээ хийх нь .....	41
Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг чанаржуулах зорилгоор	

Санхүүгийн Мэдээллийн Албаны мэдээлэл гаргах чадамжийг нэмэгдүүлэх нь .....	44
Сэжигтэй гүйлгээний тайлан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой бусад мэдээлэлд хийх дүн шинжилгээ .....	45
Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зорилгоор хилээр нэвтэрч буй бэлэн мөнгөний гаалийн мэдүүлэгт хийх дүн шинжилгээ .....	47
<b>VI. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ АРГА .....</b>	<b>50</b>
<b>VII. СУРГАЛТ .....</b>	<b>59</b>
<b>VIII. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА .....</b>	<b>62</b>
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>66</b>
<b>САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ .....</b>	<b>73</b>

# САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ

## I. ЗӨВЛӨМЖИЙН ЗОРИЛГО

1. Олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-н стандартын хамгийн сүүлийн шинэчилсэн найруулгыг боловсруулах явцад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох мөрдөн шалгах ажиллагааны бүтэц, хамрах хүрээнд илүү анхаарал хандуулсан болно. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хэрэг, гэмт хэргийн орлогыг олж илрүүлэх хууль сахиулах байгууллагын чиг үүргийг өргөжүүлэх, бэхжүүлэх, түүнтэй холбоотой хариуцлага, эрх хэмжээг нэмэгдүүлэх, арга ажиллагааг сайжруулах замаар хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаан дахь стандарт (ФАТФ-н Зөвлөмж 30 ба 31)-г сайжруулахыг зорилоо. Одоогийн шинэчлэн батлагдсан ФАТФ-н зөвлөмжид санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь хууль сахиулах болон мөрдөн шалгахтай холбоотой зөвлөмжүүдээс хамгийн чухалд тооцогддог. Уг зөвлөмж нь гагцхүү хууль сахиулах байгууллагын эзлэх байр суурь, үүрэг, тэр дундаа санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үүрэг, зориулалтыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тогтоолцооны мөн чанар, агуулгатай өргөн утгаар нь илүү уялдуулж ойлгоход улс орнуудад туслахад чиглэсэн бөгөөд тухайн зөвлөмж нь заавал биелүүлэх стандарт эсхүл тайлбар биш болохыг тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү зөвлөмжийн зорилго нь МУТСТ тогтоолцоон дахь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд тус дөхөм болох шинэлэг ойлголт, үзэл санааг нутагшуулах чиг үүрэгтэй ажиллаж буй бодлого боловсруулагч болон мэргэжлийн салбарыханд туслалцаа үзүүлэхэд оршино. Хэдийгээр эдгээр шинэлэг ойлголт, үзэл санаа нь тогтсон стандартаас өөр агуулга, ойлголттой байж болох хэдий ч бусад улс орон санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хэрхэн

явуулдаг жишээ, нотолгоо байж болох талтай. Түүнчлэн, энэхүү зөвлөмж нь цаашид МУТСТ тогтолцоонд үнэлгээ хийх явцад ашиг тустай байж болохоос гадна мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд ашиглаж буй арга, ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд тус дөхөмтэй байх болно.

2. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа гэдэгт энэхүү зөвлөмжийн хүрээнд гэмт үйл ажиллагааны мөнгө, санхүүтэй холбогдсон бүх талын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйл явцыг судлахыг ойлгоно. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үндсэн зорилго нь гэмт хэрэг үйлдэгдэх явц дахь мөнгө, хөрөнгийн хөдөлгөөнийг илрүүлэх, баримтжуулахад оршино. Мөнгөний гарал үүсэл ба эцсийн өмчлөгч хоёрын хоорондын холбоос, мөнгө хүлээн авсан хугацаа, хадгалагдаж буй байршил эсхүл байршуулсан банк, санхүүгийн байгууллагын мэдээ, мэдээлэл нь гэмт үйл ажиллагааны мэдээллийн эх сурвалж болохоос гадна гэмт хэргийн нотлох баримт болдог.<sup>1</sup> Гэмт үйлдлийн цар хүрээг тодорхойлох, гэмт хэрэгт оролцогч, бүлэглэлийг илрүүлэх, гэмт хэргийн улмаас олсон орлого, мөнгө, хөрөнгө, терроризмын санхүүжилтийн эх үүсвэр болон улсын орлого болгож хураах бусад хөрөнгө, эх үүсвэрийг эрэн сурвалжилж олж тогтоох, түүнчлэн шүүхийн шатанд ашиглагдаж болзошгүй нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэх нь тухайн улсын МУТСТ тогтолцоог ерөнхийд нь үр нөлөөтэй болгоход түлхэц болдог. Энэхүү зөвлөмж нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны цогц арга барил, стратеги, арга зүйн асуудлыг хөндөн авч үзэж буй бөгөөд эрх зүйн тогтолцооны хувьд өөр хоорондоо ялгаатай, мөрдөн шалгах ажиллагааны төрөл бүрийн хэв загвартай улс оронд хэрэглэгдэх боломжтой ба ФАТФ-н санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахтай холбоотой зөвлөмжийг үр дүнтэй хэрэглэхэд чиглэгдэх болно. Уг зөвлөмж нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах сургалтын гарын авлагад тооцогдохгүй хэдий ч санхүүгийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг мөрдөн байцаагч болон прокурорын хувьд

---

<sup>1</sup> ФАТФ-н 30 дугаар зөвлөмжийн тайлбарыг үзэх. (2012 он.), 2 дахь догол мөр.



судлах шаардлагатай сургалт, техникийн туслалцааны илүү онцлогтой болно.<sup>2</sup> Энэхүү зөвлөмж нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны талаар дэлгэрэнгүй ойлголт, төсөөлөлтэй болоход шаардлагатай эх сурвалжийн холбоос, ишлэлийг агуулсан болно.<sup>3</sup>

3. Гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах чиг үүрэгтэй байгууллагын зүгээс ФАТФ-н Зөвлөмжид тусгагдсан санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны талаар тавигдаж буй шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд улс орнууд эдгээр шаардлагыг хэрэгжүүлэх боломжтой гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах ажиллагааны иж бүрэн эрх зүйн зохицуулалттай байвал зохино. Харин мөрдөн шалгах ажиллагааны тусгай арга, техникийг зөвхөн тухайн улсын дотоодын эрх зүйн тогтолцооны үндсэн зарчмын хүрээнд зөвшөөрөгдсөн тохиолдолд хэрэглэж болно.

Энэхүү зөвлөмж нь хууль сахиулах байгууллагын зүгээс эрх хэмжээгээ хэрэгжүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад шаардагдах арга, техникийн талаарх Палермогийн Конвенц<sup>4</sup>-н үндсэн ойлголт, үзэл санааг онцгойлон хөндсөн болно.

## **ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГАТАЙ ХОЛБОГДОХ СТАНДАРТ**

4. ФАТФ-н зөвлөмж нь хууль бус санхүүгийн үйл ажиллагааг илрүүлэх, санхүүгийн зах зээлийн нэгдмэл байдлыг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх, үндэсний аюулгүй байдалд учруулж буй аюул, заналхийллээс урьдчилан сэргийлэх зорилготой баримт бичиг мөн. Хууль сахиулах байгууллага мөнгө угаах, мөнгө угаахын суурь гэмт хэрэг, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг илрүүлэх, таслан

<sup>2</sup> Удирдамжид хөндөгдөж буй асуудалтай холбогдуулан “прокурор” гэдэг ойлголт “мөрдөн шалгах ажиллагааны магистрат”, “мөрдөн шалгах ажиллагааны шүүгч” гэсэн нэр томъёонууд хамаарна.

<sup>3</sup> Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаатай холбогдох эх сурвалжийн жагсаалтыг энэхүү зөвлөмжийн төгсгөл хэсгээс үзнэ үү.

<sup>4</sup> НҮБ-н Конвенци (2000 он).

зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажлаа зохион байгуулж ажиллах үүрэгтэй. Түүнчлэн, хууль сахиулах байгууллага гэмт этгээдийн хууль бусаар олсон орлогыг, террористуудын алан хядах үйл ажиллагааг санхүүжүүлэхэд шаардлагатай эх үүсвэр, нөөц, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглох, улмаар уг эд хөрөнгө, эх үүсвэрийг салгаж тусгаарлах тууштай хүчин чармайлт гаргаж ажиллах үүрэгтэй. Хууль сахиулах байгууллагын санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүрэг, оролцоог нарийн тайлбарлахаар чиглэгдэж буй энэхүү зөвлөмжийн хувьд дараах ФАТФ-н зөвлөмж чухал байр суурь эзлэнэ. Үүнд:

**5. Үндэсний хэмжээний хамтын ажиллагаа, уялдаа холбоо.** ФАТФ-н шинэ зөвлөмжийн дагуу улс орнууд үндэсний хэмжээний МУТС-тэй тэмцэх бодлоготой байх (Зөвлөмж 2). Уг бодлого нь ил болсон эрсдэлд суурилсан байх бөгөөд уг бодлогыг цаг үеийн нөхцөл байдалд нийцсэн, алдаа мадаггүй байлгахын тулд тогтмол шинэчилж байх хэрэгтэй. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулсны үр дүнд олж авсан мэдлэг, мэдээлэл нь эрсдэлийн үнэлгээ, нөхцөл байдалд мониторинг хийхэд үр өгөөжтэй байж болно. Улс орнууд мөнгө угаах болон түүнтэй холбоотой суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндэсний бодлого, хууль тогтоомжтой байх хэрэгтэй. Түүнчлэн, улс орнуудын эрх бүхий байгууллага албан ёсны харилцан хамтын ажиллагааны механизмтай байх хэрэгтэй. Ингэснээр дээр дурдсан бодлого, хууль тогтоомжийг бий болгож нэвтрүүлэх боломжтой. Үүний үр дүнд байгууллага хоорондын албан ба албан бус хамтын ажиллагаа нийтлэг байдлаар хөгжихийн зэрэгцээ хууль сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагаа сайжирдаг.

**6. Статистик.** ФАТФ нь үр дүнтэй байдалд онцгой анхаардаг. Мэдээлэл цуглуулах нь улс орнуудын санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнтэй байдлыг тодорхойлох голлох шалгуур болдог. Тухайлбал, мөнгө угаах гэмт хэрэгтэй, түүнтэй холбоотой үйл ажиллагааг эрүүгийн процессын журмаар

санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар хянан шийдвэрлэдэг бөгөөд гэмт этгээд хуульд заасан нөхцөл, журмын дагуу шалгагдаж, зохих ял шийтгэлээ хүлээх учиртай. ФАТФ-н 33 дугаар зөвлөмж нь улс орнуудаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүн, үр ашигтай байдалтай холбоотой асуудлаар иж бүрэн дэлгэрэнгүй статистикийн мэдээлэл хөтлөхийг шаарддаг. Статистик мэдээлэл нь хүлээн авсан болон шилжүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээр мөрдөн шалгасан, ялласан, шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо баримт; царцаасан, битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийн хэмжээ, олон улсын болон үндэсний түвшний хамтын ажиллагааны хүрээнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт болон бусад олон улсын шинжтэй мэдээлэл гаргуулахаар хүргүүлсэн болон хүлээн авсан хүсэлтийн тоо, хэмжээ зэрэг бусад мэдээллээс бүрдэнэ.

**7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг.** ФАТФ-н 3 болон 5 дугаар зөвлөмж нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг бие даасан гэмт хэрэгтэй дүйцүүлэн гэмт хэрэгт тооцохыг шаарддаг. Эдгээр төрлийн гэмт хэрэгт санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахгүйгээр амжилттай хянан шийдвэрлэх нь туйлын хүндрэлтэй байдаг. Энэхүү зөвлөмж нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг улс орнуудын зүгээс мэргэжлийн түвшинд, жинхэнэ утгаар нь явуулах чадамжийг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэхэд оршино.

**8. Хураан авах болон түр зуурын арга хэмжээ.** ФАТФ-н Зөвлөмж 4 ба 38<sup>5</sup> нь улсын орлого болох хөрөнгийг олж тогтоох, тодорхойлох, үнэлэх арга хэмжээтэй холбоотой харилцааг тодорхойлдог. Уг зөвлөмж нь хөрөнгийг хэн нэгэнд арилжаалах, шилжүүлэх, устаж үгүй болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор царцаах, битүүмжлэх арга хэмжээ авахыг уриалдаг.

---

<sup>5</sup> ФАТФ (2010): Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны эх сурважлийн жагсаалтыг энэхүү зөвлөмжийн төгсгөлд хавсаргасан болно.

**9. Хууль сахиулах байгууллага болон мөрдөн шалгах байгууллагын үүрэг.** ФАТФ-н 30 дугаар зөвлөмж нь улс орнуудыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах тусгайлсан мөрдөн байцаагчтай байхыг шаарддаг. Түүнчлэн, санхүүгийн зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагаа зайлшгүй явуулах, олон улсын мөрдөн шалгах байгууллагыг татан оролцуулах, хамтарсан мөрдөн шалгах ажлын хэсэг байгуулан ажиллах гэсэн шаардлагыг тавьдаг. Тиймээс, хууль, эрх зүйн орчин нь мөрдөн шалгах ажлын хэсэг байгуулж ажиллуулахад саад учруулахааргүй байна. ФАТФ-н 30 дугаар зөвлөмж нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй мөрдөн байцаагч нарт хамааралтай. Энэхүү зөвлөмжийн тайлбар нь тодорхой төрлийн хуулиар харьяалуулсан хэрэгт<sup>6</sup> мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэгтэй хууль сахиулах байгууллагын мөрдөн байцаагч нар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зөрчил, гэмт хэргийг санхүүгийн зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөн шалгах эсхүл тухайн хэргийг мөрдөн шалгах эрхийг өөр байгууллагад шилжүүлэх эрх хэмжээтэй байхыг шаарддаг. Үүнээс гадна, энэ зөвлөмж нь гагцхүү 30 дугаар зөвлөмжид заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллагад зориулагдсанаас гадна хууль сахиулах чиг үүрэггүй эрх бүхий байгууллагад мөн зориулагдсан болно. Тухайлбал, хууль сахиулах эрх хэмжээтэй авлигатай тэмцэх байгууллага, татварын байгууллага нь ФАТФ-н 30 дугаар зөвлөмжид дурдагдсан авлига болон татварын онц ноцтой хэргүүдтэй холбогдсон гэмт хэргийн орлого, хөрөнгө, мөнгөтэй холбоотой мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх хэргийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй байж болно. Ийм тохиолдолд эдгээр байгууллага тухайн улс орны үндэсний хууль тогтоомжийн дагуу хөрөнгө илрүүлэх, олж тогтоох, царцаах, түр хураан авах хангалттай эрх хэмжээтэй байна. Хэрвээ прокурор нарийн төвөгтэй санхүүгийн болон

---

<sup>6</sup> ФАТФ-н нэр томъёоны тайлбарыг үзнэ үү (2012).

зохион байгуулалттай хэрэгт мөрдөн шалгах ажиллагааны нөөц бололцоог удирдан чиглүүлэх зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатай болсон тохиолдолд энэ зөвлөмж прокуроруудад хамааралтай. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон гэмт хэргийг яллахад шаардагдах нотлох баримтыг бэлтгэхэд прокурор олон төрлийн асуудал хариуцах шаардлагатай болдог. Хэдийгээр санхүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг тусгай мөрдөн байцаагч нарыг бэлтгэхэд онцгой анхаарал хандуулдаг ч бусад бүх төрлийн хэрэгт эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг бүх мөрдөн байцаагчид санхүүгийн мэдээлэл нь бүх төрлийн эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгахад ямар өндөр ач холбогдолтой болохыг онцолсон тусгай сургалт явуулах шаардлагатай. Санхүүгийн мэдээллийг нарийн төвөгтэй, үргэлжилсэн мөрдөн шалгах ажиллагаанд ашиглахын зэрэгцээ санхүүгийн мэдээллийг “гудамжны” гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах нь ямар их үнэ цэнэ, ач холбогдолтой болох талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх ёстой. Ийм маягаар мөрдөн байцаагч, прокуроруудын санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд хандах хандлагыг өөрчлөх нь зүйтэй. Энэхүү зөвлөмж нь хууль тогтоогч нарт хэрэг болж болохын зэрэгцээ сургалт, техникийн туслалцаа үзүүлж буй хүмүүст хэрэг болно.

**10. Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын эрх хэмжээ.** ФАТФ-н 31 дүгээр зөвлөмж нь мөнгө угаах, түүнтэй холбогдох суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага нь мөрдөн шалгах ажиллагаанд шаардлагатай бүхий л баримт бичиг, мэдээлэлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй байхыг онцлон тэмдэглэдэг. Эдгээр эрх хэмжээнд санхүүгийн баримт, сэлт, нотлох баримт цуглуулах эрх хэмжээ хамаарна. Энэхүү зөвлөмж нь халхавчилсан арга хэмжээ зохиох, харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих, компьютерийн системд нэвтрэх, хяналттай хүргэлт хийх зэрэг мөрдөн шалгах ажиллагааны өргөн хүрээтэй арга, техникийг ашиглах чадвартай байхыг шаарддаг. Энэхүү зөвлөмжийн 6 дугаар хэсэгт мөрдөн шалгах

ажиллагааны арга техникийн талаар дэлгэрэнгүй тайлбарлана. Түүнчлэн, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллага дансны эзэмшигч болон захиран зарцуулах эрхтэй этгээд, түүний хөрөнгийг тухайн эзэмшигчид урьдчилан мэдэгдэлгүйгээр илрүүлэх, олж тогтоох механизмтай болохыг онцгойлон шаарддаг. Мөн эрх бүхий байгууллага нь Санхүүгийн Мэдээллийн Албанаас мэдээлэл гаргуулах, ашиглах эрх хэмжээтэй байх ёстой.

**11. Олон улсын хамтын ажиллагаа.** ФАТФ-н 40 дүгээр зөвлөмж нь улс орнуудыг олон улс, бүс нутгийн хэмжээнд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг мөрдөн байцаагч нараас мэдээлэл хүлээн авах, харилцан солицох механизм бий болгохыг шаарддаг. Улс орнууд үндэстэн дамнасан санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд туслалцаа, дэмжлэг үзүүлэхийн тулд мөрдөн байцаагч нарт эрх хэмжээгээ ашиглах механизм бий болгох шаардлагатай. Олон улсын хамтын ажиллагааны талаарх тус зөвлөмж нь улс орнуудын хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллага бусад улс орны ижил төстэй байгууллагатай хамтарсан мөрдөн шалгах ажлын хэсэг байгуулж ажиллах механизмыг хүлээн зөвшөөрөх, тухайн улс оронд холбогч ажилтныг томилж ажиллуулахыг хэвшүүлэн дэмжихийг шаарддаг. Зарим төрлийн хамтын ажиллагаанд хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны шугамаар ажиллаж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах замаар хамтын ажиллагааг хөгжүүлж болно. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг мөрдөн байцаагч, ажилтнууд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд тогтмол бус харилцаатай (байнгын түнш бус) ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, мөрдөн байцаагч нартай стратегийн харилцан ашигтай хамтын ажиллагааг шууд ба шууд бусаар хөгжүүлэн бэхжүүлэхийг зөвлөдөг. Түүнчлэн, олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хүсэлтэд хариу авсан улс нь тухайн мэдээллийг зөвхөн хууль сахиулах болон мөрдөн шалгах ажиллагааны зорилгоор ашиглах ба тухайн мэдээлэл задрах,

үрэгдэхээс хамгаалах үүрэгтэй. Түүнээс гадна, тус зөвлөмж нь улс орнуудыг албан бус шугамаар мэдээлэл солилцох журам батлуулж хэрэгжүүлэх (албан ёсны харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт явуулахаас өмнө). Өөрөөр хэлбэл, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт явуулахаас өмнө албан бус хамтын ажиллагааны бүхий л хэлбэрийг ашиглан, боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгодог.

**12. Бэлэн мөнгө зөөвөрлөгчид.** ФАТФ-н 32 дугаар зөвлөмжтэй холбоотой мэдээлэл цуглуулах, баримтжуулах, хуваалцахтай холбоотой шаардлага санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцад үнэлж барамгүй. Хэрэв гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж буй этгээд, тэдгээрийн хань хамсаатан нь өмнө нь бэлэн мөнгө хилээр нэвтрүүлэх мэдүүлэг бөглөсөн байвал мөрдөн шалгах ажиллагаанд ихэнхдээ үр ашигтай байдаг. Эдгээр гаалийн мэдүүлэг нь мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа болон бусад эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад сэжигтэй этгээдийн идэвхтэй ба идэвхгүй үйлдлийн талаарх мэдлэг, санаа зорилгыг зарим тохиолдолд тогтооход ач холбогдолтой байдаг. ФАТФ-н 32 дугаар зөвлөмж<sup>7</sup> нь валют болон төлбөрийн хэрэгслийн хөдөлгөөнийг мөшгин илрүүлэх зорилготой арга хэмжээ нэвтрүүлэхэд чиглэгдсэн байдаг бол санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь ФАТФ-н 32 дугаар зөвлөмжид заасан дэглэмийг хөгжүүлэх чухал бүрэлдэхүүн хэсэг билээ.

## **САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО, ҮР ӨГӨӨЖ**

13. Улс орнууд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг орлого хуримтлуулах боломжтой голлох гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэх арга ажиллагааны “тулгын чулуу”, “тэмцлийн гол хэрэгсэл” болгох баталгааг хангах шаардлагатай бөгөөд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь дараах үндсэн зорилготой:

<sup>7</sup> ФАТФ (2015).

- Гэмт хэргийн улмаас олсон орлогыг илрүүлэх, нуугдмал хөрөнгийг олж тогтоох, шаардлагатай бол царцаах (бүтүүмжлэх), түр хураах түр зуурын арга хэмжээ авах замаар хөрөнгийг улсын орлого болгох арга хэмжээг эхлүүлэх;
- Шаардлагатай бол мөнгө угаах хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах;
- Санхүүгийн болон эдийн засгийн үндэс, бүтэц, зохион байгуулалтыг илрүүлэх, үндэстэн дамнасан гэмт хэргийн сүлжээг задлан сарниулах, гэмт үйл ажиллагааны чиг хандлага, хэв маягийн талаар мэдлэг олж авах.

14. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь гэмт хэргийн улмаас олсон орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгслийг хурааж авах, мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэдээ, мэдээлэл цуглуулах, цугларсан бүх мэдээллийг харьцуулж, дүн шинжилгээ хийх гэсэн хэсгээс бүрддэг. Гэмт этгээдүүд ихэнхдээ өөрийн хөрөнгийг тодорхой түвшинд хяналтад байлгахыг илүүд үздэг нь эцсийн үр дүнд “цаасан дээрх ул мөр” үлдээдэг. Энэ нь эргээд ерөнхийдөө гэмт этгээд рүү чиглүүлж өгдөг. Эдгээр “цаасан дээрх ул мөр” нь бусад гэмт этгээд, хань хамсаатныг олж тогтоох, түүнчлэн, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгсэл, нотлох баримтыг илрүүлэх боломжит сэжүүр болдог. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах хууль сахиулах байгууллагын мэргэжлийн ур чадвар, санхүүгийн болон бусад мэдээлэлд нэвтрэх боломж нь мөнгө угаах, түүний суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх амин чухал нөхцөл билээ. Ийм мөрдөн шалгах ажиллагаа нь өмнө нь эзэн холбогдогч нь тодорхойгүй байсан хэргийг илрүүлэх, гэмт хэргийн улмаас олсон орлогоор худалдаж авсан хөрөнгийг олж тогтоох, улмаар эдгээр хөрөнгийг улсын орлого болгож хураах боломж олгодог.

15. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь урьд өмнө нь илрээгүй суурь гэмт хэрэг болон бусад холбогдох хүн, аж ахуйн нэгжийг илрүүлэх арга хэрэгсэлд тооцогддог.



Тиймээс санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны бүхий л үе шатанд санхүүгийн тагнуулын боломжийг бүрэн гүйцэт ашиглах нь нэн чухал. Энэ утгаараа санхүүгийн тагнуулын мэдээлэл нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, хэм хэмжээний акт, журмын дагуу зохицуулах, хяналт тавих, хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллага болон бусад эрх бүхий байгууллагын хооронд чөлөөтэй эргэлтэд орж байх ёстой. Иймд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь үйл явцад тулгуурласан бус үр дүнд тулгуурласан байна. Хэрэв санхүүгийн мэдээ, мэдээллийг үр дүнтэй солилцдог тогтолцоо бүрэлдвэл улс орнууд эдгээр мэдээ, мэдээллийг илүү үр дүнтэй ашигладаг болохын зэрэгцээ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон их хэмжээний орлого хуримтлуулдаг гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцдэг болно.

16. Улс орнууд мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд шалгагдаж буй хүмүүсийн хуулиар хамгаалагдсан эрхийг хамгаалах зохистой арга хэмжээ авах үүрэгтэй. Санхүүгийн мэдээлэл гаргуулах хүсэлт, лавлагаа нь ихэнх тохиолдолд бусдын нууцад халддаг ба түүний үр дүнд хувь хүний мэдээллийг олж авдаг. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг эрх бүхий байгууллага, хувь хүний нууцтай холбоотой үндэсний хууль тогтоомж, бусад шаардлагын талаар мэдлэгтэй байх хэрэгтэй. Мөрдөн байцаагч нар санхүүгийн мэдээлэл гаргуулах хүсэлт, лавлагааны үндэслэлийг тэнцвэртэй, бусдыг ялгаварлан гадуурхах зорилгогүй, хууль ёсны, хариуцлагатай, мөрдөн шалгах ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцсэн гэдгийг батлах боломжтой. Ийм арга хэмжээ нь ихэнхдээ шалгагдаж, хүмүүсийг шударга шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх, гэмт хэрэг нь шүүхээр нотлогдоогүй бол гэм буруутайд үл тооцох, өмчлөх эрхээ хамгаалах эрхээ тус тус хэрэгжүүлэх боломжоор хангадаг.

## II. САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ

### МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

17. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь нийт гэмт хэрэгтэй тэмцэх стратегийн салшгүй хэсэг мөн. Улс, орнууд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь хууль сахиулах бодлогын салшгүй хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч түүний үүрэг, ач холбогдлыг онцолсон иж бүрэн эрх зүйн зохицуулалт бий болговол зохино. Үр дүнтэй санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны бодлоготой улс орны санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь тодорхой, ойлгомжтой зорилго, зорилттой, авч буй арга хэмжээ, явуулж буй үйл ажиллагаа нь зөвхөн тухайн зорилтыг биелүүлэхэд зориулагдсан, хангалттай эх үүсвэр, нөөц бололцоогоор хангагдсан, хуулиар олгогдсон эрх хэмжээг өргөн хүрээнд, бүрэн дүүрэн, бүтээлч, тууштай, ухамсар, хариуцлагатай ашиглах чадамжтай байна. Улс орнууд санхүүгийн үр ашиг, орлого хуримтлуулдаг гэмт хэрэгт явуулдаг хяналт, шалгалтын хүрээнд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга хэрэгсэл, техникийг ашигладаг болгох тогтсон дэг журмыг тогтоох чиглэлээр идэвхтэй арга хэмжээ авбал зохино.

18. Улс орнууд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж хэвшүүлэхийн тулд үр дүнтэй, хэрэгжих боломжтой бодлого, стратегийг идэвх санаачилга гарган боловсруулах үүрэгтэй. Дор дурдсан санаачилга стратегийн төлөвлөгөөнд агуулагдаж болно. Үүнд:

- Үндэсний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийг олон нийтийн түвшинд уриалан дэмжиж хүлээн зөвшөөрдөг нөлөө бүхий, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны зүгээс дэмжлэг авах боломжийг эрэлхийлэх;
- Дотоодын дээд албан тушаалтны зүгээс үндэсний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй

тэмцэх стратегийг дэмжих, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг хүлээхээ илэрхийлж буй олон нийтийн мэдэгдэл гаргах;

- Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг эрх бүхий бүх байгууллагын мэдлэг, ур чадварыг нэгтгэх боломжтой бодлогын түвшний үр дүнтэй арга хэмжээ боловсруулах зорилгоор стратеги төлөвлөлтийн ажлын хэсэг байгуулж, улмаар үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө гаргах;
- Хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үнэлгээ хийж, эх үүсвэр, нөөц бололцоог зүй зохистой хуваарилахад дэмжлэг үзүүлэх;
- Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэгтэй тусгайлсан алба, нэгж байгуулах;
- Хөрөнгө битүүмжлэх/царцаах эрх хэмжээг угтуулан, цаг алдалгүй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны санаачилга боловсруулах;
- Эрх бүхий байгууллага, албадын зорилго, зорилтыг тодорхой, ойлгомжтой томъёолж, харилцан уялдаатай, хяналттай механизм бий болгох.

19. Улс орнууд санхүүгийн гэмт хэрэг мөрдөн шалгах мэдлэг, ур чадвартай, хүрээлцээтэй мөрдөн байцаагч нартай байхын тулд тэдгээрийг сургаж бэлтгэх ажлыг үндэсний хууль тогтоомж болон бусад бодлогын баримт бичигт тэргүүлэх зорилт болгон баталгаажуулбал зохино. Санхүүгийн мөрдөн байцаагч нар нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах дадал, туршлагатай байхын зэрэгцээ үндэсний хууль тогтоомж болон олон улсын конвенци, стандартын талаар мэдлэгтэй байх ёстой. Улс орнууд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах зүй зохистой орчин нөхцлөөр хангасан институцийн орчныг бүрдүүлэх, улмаар санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад ФАТФ-н 31 дүгээр зөвлөмжид заасан зохих хууль ёсны эрх мэдлийг олгох замаар хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Санхүүгийн

мөрдөн шалгах ажиллагааны аргуудыг “уламжлалт” гэмт хэрэг, ашиг орлого хуримтлуулдаг мөнгө угаахын суурь гэмт хэргийг мөрдөн шалгахад хослуулан ашигладаг байвал зохино. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх хэмжээтэй тусгайлсан алба, нэгж нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны тусгай мэдлэг, ур чадвар дутагдаж байгаа бусад эрх бүхий байгууллагад дэмжлэг үзүүлж нягт уялдаатай хамтран ажиллах боломжтой байх нөхцлийг улс орнууд бүрдүүлж, ийм хамтын ажиллагааны хэлбэрийг цаашдын үйл ажиллагаандаа “хэвшүүлэх”.

20. Улс орнууд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа алсын хараатай хандахын зэрэгцээ хөрөнгө хураах чиг үүрэгтэй эрх бүхий байгууллага, хууль сахиулах байгууллага, санхүүгийн тагнуулын албаны зүгээс хөрөнгө нөхөн төлүүлэх үйл ажиллагааны явцад шинжээчдийг хөлслөх, орчуулга хийлгэх, хилийн чанадад томилолтоор ажиллахад гарсан зардал зэргийг санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд улсын орлого болгож хураасан хөрөнгөөр нөхөн төлүүлэх хөтөлбөр бий болгож хэрэгжүүлэх.

## **МӨРДӨН ШАЛГАХ ЗЭРЭГЦЭЭ АЖИЛЛАГАА**

21. Мөрдөн шалгах зэрэгцээ ажиллагаа гэдэгт санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны утга агуулгаараа суурь гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хүч, хэрэгслийг нэгэн зэрэг төвлөрүүлж ажиллахыг ойлгоно. Терроризмын утга агуулгаараа мөрдөн шалгах зэрэгцээ ажиллагаа гэдэгт терроризмын гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт нэгэн зэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг ойлгоно.<sup>8</sup> Хууль сахиулах байгууллага мөнгө угаах гэмт хэргийн аливаа суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой аливаа хэрэгт мөрдөн шалгах зэрэгцээ ажиллагаа явуулна гэж ФАТФ-н 30 дугаар зөвлөмжид заасан. Мөрдөн шалгах зэрэгцээ ажиллагааны гол үзэл санаа нь уламжлалт мөрдөн шалгах

---

<sup>8</sup> Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой III хэсэгтэй танилцана уу.

ажиллагаа болон санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг зэрэгцүүлэн явуулснаар мөрдөн байцаагч нар дор дороо мэргэшсэн мөрдөн шалгах ажиллагааныхаа тогтсон арга барил, туршлага, мэдлэгээс хуваалцах, нэг мөрдөн шалгах ажиллагааны сул талыг нөгөө мөрдөн шалгах ажиллагааны давуу талаар харилцан нөхөх боломж гарах ба ингэснээр хэргийг бүрэн дүүрэн шалган шийдвэрлэх боломжтой.

22. Суурь гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг угтан явуулах нь гэмт хэргийн улмаас олсон орлого, хөрөнгө, мөнгийг олж тогтоох, улмаар түр саатуулан хураах боломжийг нээж өгдөг. Ингэснээр гэмт хэргийн улмаас олсон орлого үрэн таран хийгдэж алга болох, хууль ёсны эдийн засагт шингэхээс урьдчилан сэргийлж, улмаар гэмт хэргийн улмаас орлого, хөрөнгө, мөнгийг ашиглан ирээдүйд гэмт хэрэг үйлдэх боломжийг хаадаг. Энэхүү жишиг, практик нь гэмт хэргээс хэн ч үр шим хүртэх ёсгүй гэсэн хууль тогтоомжид ч бэхжсэн, олон нийтийн дунд ч хүлээн зөвшөөрөгддөг зарчмыг мөрдөхөд баталгаа болж өгдөг.

23. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь их хэмжээний мэдээ, мэдээлэл, өгөгдөл боловсруулахыг шаарддаг ажиллагаа юм. Ялангуяа, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд мөнгөний хөдөлгөөнийг олж тодорхойлоход тустай банкны дансны хуулга мэтийн бүртгэл хамаардаг. Мөнгөтэй холбоотой үйл ажиллагаа, үйл явдал, түүний өрнөлийг цаасан дээр харуулж байгаа аливаа бүртгэл, мэдээлэл туйлын чухал байдаг. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны гол зорилго нь гэмт хэрэг үйлдэгдэх явцад мөнгөний хөдөлгөөнийг олж тодорхойлох, баримтжуулах явдал байдаг. Мөнгө хаанаас орж ирсэн, хэн хүлээж авсан, хэзээ хүлээж авсан, хаана хадгалсан эсхүл хаана байршуулсан зэрэг мэдээллийн хооронд ямар нэгэн уялдаа, холбоо харагдвал гэмт үйл ажиллагааг нотлох баримт болдог. Түүнчлэн, суурь гэмт хэрэгт мөрдөн шалгах зэрэгцээ ажиллагаа явуулахад санхүүгийн мэдээлэл нь дараах байдлаар тусалдаг. Үүнд:

- Гэмт хэргийн сэдлийг тодорхойлох, гэмт хэргийн

хамтран оролцогчийг илрүүлэх, бусад оролцогч руу чиглүүлэх, газар орныг зааж өгөх;

- Хэрэг үйлдэхэд ашигласан холбооны үйлчилгээ, тэр дундаа үүрэн холбооны утасны дугаар, тээврийн хэрэгсэл, үл хөдлөх эд хөрөнгө, бусад эд зүйлийг олж тогтоох;
- Сэжигтэн, гэрч болон хохирогчийн байршлыг тогтоох, тэдгээрийг тодорхойлох;
- Сэжигтний байрлал, хөдөлгөөний талаарх мэдээллээр хангах (угтан тагнах зорилго агуулдаг, санхүүгийн мэдээллийг нууц далд үйл ажиллагаанд ашигладаг);
- Өмнө нь ямар нэгэн байдлаар гол сэжигтнийг буюу хэргийн зохион байгуулагч этгээдийг олж тодорхойлох арга амжилтгүй болсон бол уг асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай чиглүүлсэн мэдээллээр хангах;
- Хүмүүсийг эрэн сурвалжлах зэрэг багтана.

24. Онц их хэмжээний орлого хуримтлуулдаг ихэнх гэмт хэргийн хувьд мөнгө угаах нь ердөө л завсрын, дайвар үйл ажиллагаа юм. Гэмт хэрэгтэн нь гэмт хэргийн улмаас олсон орлогыг ямар нэгэн байдлаар захиран зарцуулахыг хүсэж байдаг. Цаасан дээрх санхүүгийн ул мөрийг дагах чадвар нь хэрэгт холбоотой баримт, үйл явдал, нөхцөл байдлыг логик болон үйл явдлын дэс дарааллаар, бүрэн зураглалаар харуулах боломж олгодгоос гадна үйл явдлын бүрэн зураглалыг хэрхэн гаргах ойлголтыг хялбаршуулдаг. Мөрдөн шалгах зэрэгцээ ажиллагаа нь “гэмт аж үйлдвэрлэл”-н бүх оролцогчийг олж тогтоох, илрүүлэхэд чиглэгдэнэ. Мөрдөн шалгах зэрэгцээ ажиллагаа нь гэмт байгууллагын дотоод шатлан захирагдах бүтцийн талаар бүрэн зураглалыг тодорхойлох, улмаар тэдгээрт хэрэг үүсгэн шалгах үүд хаалгыг нээж өгдөг.

25. Мөрдөн шалгах зэрэгцээ ажиллагааны явцад олсон

тагнуулын мэдээ<sup>9</sup>, мэдээ нотлох баримтыг мөрдөн шалгах ажиллагаанд оролцогч талууд солилцож болох ба ажлын давхардлаас зайлсхийхийн тулд нөөц, бололцоогоо үр дүнтэй хуваарилан ашиглахыг эрэлхийлэх хэрэгтэй. Тухайлбал, суурь гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд зөвхөн суурь гэмт хэрэгт бус харин түүнтэй холбоотой мөнгө угаах үйл ажиллагаанд мэдээлэл, нотлох баримт цуглуулах зорилгоор, зохих журмын дагуу харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих гүйцэтгэх ажлын арга хэмжээ ашиглаж болно. Энэ тохиолдолд гүйцэтгэх ажлын арга хэмжээний үр дүнд олж тогтоосон, баримтжуулсан мэдээллийг хөрөнгө царцаах, битүүмжлэх, түр хураах мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах шийдвэр гаргахад ашиглаж болно. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь суурь гэмт хэргийг бүрэн дүүрэн, иж бүрэн мөрдөн шалгахад жинтэй хувь нэмэр оруулдаг. Учир нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд сэжигтний амьжиргааны түвшин, тайлбарлах боломжгүй хөрөнгө, баялгийг ил болгох ба улс орны ийм төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогоос шалтгаалан энэ нь шууд бус нотлох баримтад тооцогдон (шүүхийн шийдвэрээр) улмаар гарал үүслийг нь тайлбарлах боломжгүй хөрөнгө, мөнгийг хууль бус үйл ажиллагаанаас олсон гэж үзэх үндэслэл бий болдог. Ингэснээр сэжигтнийг мөнгө угаах болон түүний суурь гэмт хэргээр яллах хангалттай нотлох баримт бүрддэг. Ийм маягаар шууд ба шууд бус нотлох баримтыг харьцуулан танилцуулах замаар хөрөнгө царцаах, хураах, битүүмжлэх үйл ажиллагааны суурийг тавих боломжтой. Тиймээс санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь гэмт бүлэг, бүлэглэлийг “хөшигний ардаас” залж, удирдаж буй этгээдийг онилоход дэмжлэг үзүүлдэг ач холбогдолтой.

26. Улс орнууд мөрдөн шалгах чиг үүрэгтэй байгууллагад зориулан санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахад зайлшгүй хийгдэх ажлын аргачилсан зөвлөмж, хяналтын хуудас эсхүл заавар боловсруулж, дотоод журамдаа нэвтрүүлэх асуудлыг харгалзан үзэх шаардлагатай. Ингэснээр санхүүгийн

<sup>9</sup> Тагнуул, тагнуулын мэдээ (intelligence) гэсэн нэр томъёо нь энэ утгаараа үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажилладаг тагнуулын байгууллагатай уялдана.

мөрдөн шалгах ажиллагааг цэгцтэй явуулахад туслах ба мөрдөн байцаагч нар үйл ажиллагаандаа мөрдвөл зохих гарын авлага, удирдамжийн нэгэн адил ашиглаж болно.

## ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГ

27. Ялангуяа, өргөн цар хүрээтэй, нарийн төвөгтэй санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад хэргийг үр дүнтэй хянан шийдвэрлэх, гэмт хэргийн улмаас олсон орлого, хөрөнгө, мөнгийг эцсийн байдлаар шүүхээр амжилттай хянан шийдвэрлүүлж, гэмт хэргийн улмаас олсон орлогыг улсын орлого болгохын тулд хамтарсан ажлын хэсэг, тусгай мэргэжилтэн, шинжээчээс бүрдсэн бүлэг байгуулах нь чухал. Байгууллага дотроо, байгууллага хооронд, ижил төстэй гадаадын түнш байгууллагын хооронд мэдээ, мэдээлэл солилцох хамтын ажиллагааг үр дүнтэй болгохын тулд бодлогын түвшний арга хэмжээ авах шаардлагатай.

28. Хамтарсан ажлын хэсэг нь эдийн засаг, санхүүгийн гэмт хэргээр мэргэшсэн мөрдөн байцаагч, санхүүгийн дүн шинжээч, нягтлан бодогч, мэдээллийн технологийн мэргэжилтэн, прокурор, хөрөнгийн удирдлагаар дагнасан мэргэжилтнээс бүрдэж болно. Шинжээчийг бусад хяналт шалгалт, зохицуулалтын байгууллага болох Санхүүгийн тагнуулын алба, татварын байгууллага, аудитын агентлаг, ерөнхий прокурорын байгууллагаас томилох эсхүл сэлгэн ажиллуулж болно. Шаардлагатай тохиолдолд хувийн хэвшлээс шинжээч, мэргэжилтнийг оролцуулж болно. Хамтарсан ажлын хэсэгт ажиллах шинжээч, мэргэжилтэн, банк санхүүгийн, бизнесийн, нягтлан бодох бүртгэлийн их хэмжээний баримт бичигт, тэр дундаа бэлэн бус мөнгөний шилжүүлэг, санхүүгийн тайлан, гаалийн болон татварын мэдүүлэгт дүн шинжилгээ хийх мэдлэг, туршлагатай байх хэрэгтэй. Ажлын хэсэгт тагнуулын шинжтэй бизнесийн болон санхүүгийн мэдээ, мэдээлэл цуглуулах, нарийн төвөгтэй гэмт үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, бүдүүвчийг илрүүлэх, санхүүгийн ул мөрийг мөрдөн мөшгих, түүнчлэн, халхавчилсан арга хэмжээ зохиох, харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих, компьютерийн



сүлжээнд нэвтрэх, хяналттай хүргэлт, худалдан авалт зэрэг тусгай мөрдөн шалгах арга хэмжээ зохиох туршлагатай мөрдөн байцаагч нар багтана. Түүнчлэн, хамтарсан ажлын хэсэгт мөрдөн шалгах ажиллагааны уламжлалт арга, тактикийн талаар мэдлэг, ур чадвартай эрүүгийн хэргийн мөрдөн байцаагч нарыг татан оруулбал зохино. Эрүүгийн хэргийг шүүхээр мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй хянан шийдвэрлүүлэхэд прокурор мөн иж бүрэн мэдлэг, ур чадвартай байх шаардлагатай.

29. Ажлын хэсэг байгуулагдсаны дараа ажлын хэсгийн гишүүдийн хооронд болон ажлын хэсгийн ажилд дайчлагдсан бүх байгууллагын хооронд үр нөлөөтэй харилцан хамтын ажиллагааны механизм бий болгох нь туйлын чухал. Байгууллага болон агентлагууд мэдээ, мэдээлэл (тагнуулын) солилцох механизм бүрдүүлээгүйгээс нарийн төвөгтэй, цогц санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа удааширч, хүндрэл учирдаг. Байгууллага доторх болон байгууллага хоорондын харилцан хамтын ажиллагаанд эергээр нөлөөлдөг дараах механизм байж болно. Үүнд:

- Ажлын давхардлаас зайлсхийх, маргаантай, зөрчилдөөнтэй асуудлаар хэлэлцүүлэг хийх, байгууллагыг хооронд нь харилцан мэдээлэлтэй байлгах зорилгоор овог, нэр нь давхардаж буй тодорхой хувь хүн, хуулийн этгээд дээр өмнө нь явуулж байсан болон одоо явуулж буй мөрдөн шалгах ажиллагааны талаарх мэдээллийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй бүх байгууллага солилцох боломжтой мэдээлэл солилцооны систем нэвтрүүлэх;
- Байгууллага дотроо болон байгууллага хооронд ашиглагддаг харилцан хамтын ажиллагааны хүрээнд мэдээлэл солилцоход эергээр нөлөөлөх дүрэм, журам нэвтрүүлэх. Ийм дүрэм журам нь стратегийн түвшинд мэдээлэл солилцоход тус дөхөмтэй;

- Байгууллага дотор болон байгууллага хооронд үүссэн аливаа маргааныг гагцхүү мөрдөн шалгах ажиллагааны ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлэдэг арга барилыг нэвтрүүлэх;
- Харилцан хамтын ажиллагааг албан ёсоор баталгаажуулахын тулд эрх бүхий байгууллагууд харилцан ойлголцлын санамж бичиг эсхүл түүнтэй адилтгах гэрээ, хэлцлийг бичгээр байгуулах боломжийг судалж үзэх шаардлагатай.

30. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын мэдлэг, ур чадварын түвшинг нэмэгдүүлэхийн тулд хөндлөнгийн мэргэжилтэн, шинжээчийг татан оролцуулж байх боломжийг бий болгох хэрэгтэй. Зарим тохиолдолд санхүүгийн дүн шинжилгээ хийх, нягтлан бодох бүртгэл явуулах, мэдээллийн технологийн практик ач холбогдолтой асуудлаар шинжээч, зөвлөхүүдийг татан оролцуулах нь ашигтай байж болно. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд хувийн хэвшлийн байгууллага эсхүл мэргэжилтнүүдийг татан оролцуулж буй тохиолдолд мэдээ, мэдээлэл задрах, мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн аюулгүй байдлын зохих арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлдэг байх шаардлагатай.

31. Улс орнууд төр, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх стратеги боловсруулвал зохино (Хавсралтыг үзэх). Хувийн хэвшлийн салбар нь санхүүгийн мэдээллийн эх сурвалж болохын хувьд өөрийн бизнесийн эрсдэл, нэр хүндийг хамгаалахыг тэргүүн ээлжинд тавьдагийн зэрэгцээ өөрсдийн эзэмшилд буй мэдээлэлд дүн шинжилгээ хийх, боловсруулах мэдлэг, ур чадвартай байдаг бөгөөд зарим тохиолдолд хууль сахиулах байгууллагын дэргэд илүү давуу байдалтай байдаг. Мэдээлэл задрах, үрэгдэхээс хамгаалах, хувь хүний нууцлал, халдашгүй байдлыг хуулийн хүрээнд хангах асуудал мэдээлэл солилцооны салшгүй хэсэг байна. Ийм учраас хууль сахиулах байгууллагын зүгээс санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахад эерэг нөлөө үзүүлдэг хүчин зүйлсийг үр

дүнтэй олж тогтоохын тулд төр, хувийн хэвшлийн хоорондын мэдээлэл солилцоог хууль тогтоомжийн хүрээнд хөгжүүлэх хэрэгтэй.

## **ХӨРӨНГӨ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА**

32. Хөрөнгийг амжилттай нөхөн төлүүлэхэд үйл ажиллагааны иж бүрэн төлөвлөгөө чухал. Төлөвлөгөөнд зорилтыг биелүүлэхэд шаардлагатай хэд хэдэн цуврал үе шат, анхааралдаа авбал зохих асуудал, эерэг ба сөрөг хүчин зүйлс тусгагдах ёстой. Эрх бүхий байгууллага хэргийн талаар бүрэн дүүрэн ойлголттой болохын тулд баримт, сэлт цуглуульж үнэлгээ хийх, багаа бүрдүүлэх, хамтран ажиллах түншүүдээ олж тогтоох, хилийн чанад дахь албан ба албан бус харилцаатай түнш байгууллага, хувь хүмүүстэй холбоо барих (хэрэг нь олон улсын эсхүл улс дамнасан шинжтэй бол), хууль зүйн болон гүйцэтгэх ажиллагааны хүндрэл, бэрхшээл, нарийн төвөгтэй асуудлаар гаргалгаа хийх, хэргийг үр дүнтэй шийдвэрлэх удирдлага зохион байгуулалтыг хангах хэрэгтэй. Улс орнууд эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааны журмаар хөрөнгө хураах хувилбараас гадна шүүхийн шийдвэргүйгээр эсхүл бүр захиргааны журмаар хөрөнгө хураах зэрэг бусад хувилбарыг авч хэрэгжүүлэх талаар алсын хараатай хандвал зохино.

33. Хөрөнгө нөхөн төлүүлэхтэй холбоотой мөрдөн шалгах ажиллагаанд хөрөнгө нь гэмт үйл ажиллагаатай холбоотой эсэх (хөрөнгөд суурилсан хураан авах ажиллагаа) эсхүл хөрөнгө нь гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэргээс олсон орлого (орлогыг хураах зорилготой)-той холбоотой эсэхийг тогтоох нотлох баримт бүрдүүлэх хамгийн ярвигтай. Эдгээр холбоосыг илрүүлэхийн тулд мөрдөн байцаагч нар хөрөнгийг гэмт хэрэгтэй холбоотой эсэхийг баттай тогтоох эсхүл байршиж буй газрыг хөдөлбөргүй олох хүртэл хөрөнгө эрэн сурвалжлах ажиллагааг явуулах үүрэгтэй. Ингэхийн тулд улс орнууд хөрөнгө хураах зорилгоор илрүүлэх, эрэн сурвалжлах чиг үүрэгтэй санхүүгийн мөрдөн байцаагч, прокурор нараас бүрдсэн тусгай хөрөнгө хураах нэгжийг байгуулах шаардлагатай. Ийм арга барил хөрсөн дээр буусан тохиолдолд

хөрөнгө илрүүлэх, эрэн сурвалжлах үүрэгтэй санхүүгийн мөрдөн байцаагч нар эрүүгийн мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааг хариуцаж буй хамтран зүтгэгч нартай нягт хамтран ажиллаж эхлэх шаардлагатай. Ийм хамтын ажиллагаа бий болоогүйгээс хэрэг шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх ба улмаар хөрөнгө хураах ажиллагааны үр нөлөөг бууруулдаг.

34. ФАТФ-н 4 ба 38 дугаар зөвлөмжийн тайлбарт дурдсаны дагуу улс орнуудын эрх бүхий байгууллага царцаасан, битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийг удирдах, шаардлагатай тохиолдолд захиран зарцуулах механизм нэвтрүүлэх шаардлагатай.<sup>10</sup> Эдгээр механизм нь дотоод үйл ажиллагаанд болон гадаад улс орнуудын<sup>11</sup> ирүүлсэн лавлагаа, хүсэлттэй холбогдуулан ашиглагдах ёстой. Гэмт хэргийн улмаас түр хураагдсан, битүүмжлэгдсэн, царцаасан хөрөнгийг зохицуулах чиг үүрэгтэй алба нь хэт өндөр үнэтэй, хадгалж, агуулахад хүндрэлтэй хөрөнгийг хураахаас зайлсхийхийн тулд мөрдөн байцаагч, прокурор нартай нягт хамтран ажиллах шаардлагатай.

35. Хөрөнгө нөхөн төлүүлэх зорилготой мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тулгамддаг асуудлын нэг нь хөрөнгө нөхөн төлүүлэхтэй холбоотой хэрэг бүр шүүх эрх мэдлийн байгууллагын олон шат дамжлага бүрээр дамждаг тул төвлөрсөн хяналт гэж байдаггүй. Хөрөнгө нөхөн төлүүлэх ажиллагаа төвлөрсөн хяналтгүй байх нь эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тогтолцоонд бөглөрөл үүсгэдэг. Үүний үр дүнд хөрөнгө нөхөн төлүүлэх ажиллагааны шат дамжлага бүр тусгаарлагдмал болох ба үе шат бүрийг салангид авч үзэхэд хүргэнэ. Ингэснээр санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, хөрөнгө царцаах, хураах ажиллагааг эхнээс нь дуустал нь ярвигтай болгодог. Үүнийг даван туулахын тулд улс орнууд хөрөнгө нөхөн төлүүлэх ажиллагааны үндэсний мэдээллийн сан байгуулах асуудлыг харгалзан үзэх шаардлагатай. Ийм

---

<sup>10</sup> ФАТФ (2010).

<sup>11</sup> See Brun, J.P., et al (2011) үзэх.

мэдээллийн сан бий болгосноор хөрөнгө нөхөн төлүүлэхтэй холбоотой хэрэг бүр эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тогтолцооны үе шат бүрээр дамжих болгонд бүртгэлд авагдах ач холбогдолтой. Ингэснээр бүх сонирхогч талын зүгээс бүх үе шатанд статистик арга зүйг ашиглан мэдээллийг төвлөрсөн байдлаар шалгах, дүн шинжилгээ хийх боломж олгоно. Энэ нь үйл явцыг удаашруулж буй хүчин зүйслийг тодорхойлж тулгамдсан асуудлыг шийдэх шийдлийг шуурхай олох боломж олгоно.

36. Ийм мэдээллийн сан нь өнгөрсөн хугацаанд хөрөнгө нөхөн төлүүлсэнтэй холботой түүхчилсэн нэгдсэн мэдээллийн эх сурвалж болохын хувьд мөрдөн шалгах ажиллагааны явцад хэргийг бүрэн дүүрэн ойлгох, эрх бүхий байгууллага хооронд хамтран ажиллахад дэмжлэг үзүүлдэг. Ийм төрлийн мэдээллийн сан нь харилцан хамтын ажиллагаанд нөлөөлж, улмаар илүү их хэмжээний хөрөнгө илрүүлэх, тэдгээрийг битүүмжлэх, түр хураах, улсын орлого болгох боломж олгодог. Үндэсний мэдээллийн сан нь хөрөнгө нөхөн төлүүлэх механизмын үр нөлөөг нэмэгдүүлж, хэрэг илрүүлэх, шийдвэрлэх ажиллагаанд цогцоор нь хандах арга барилын тулгуур нь болж өгдөг. ФАТФ-н 33 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай статистик мэдээллийг дээр дурдсан мэдээллийн сангаас гаргуулж болно.

## **БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ**

37. ФАТФ-н 24 дүгээр зөвлөмжид заасны дагуу улс орнууд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон хуулийн этгээдийг удирдаж, хяналт тавьж буй этгээдийн талаар шаардлага хангасан, хүрэлцээтэй, алдаа мадаггүй, цаг үеэ олсон мэдээллийг олж авах боломжтой механизм бүрдүүлсэн байх шаардлагатай. Эрх бүхий байгууллага цаг тухай бүр ийм мэдээлэлд нэвтрэх, олж авах боломжтой байна. Үүнээс гадна, ФАТФ-н 25 дугаар зөвлөмжид заасны дагуу улс орнууд итгэлцэл, тэр дундаа үүсгэн байгуулагч, итгэмжлэгдсэн этгээд, үр шим хүртэгч нарын талаар шаардлага хангасан, хүрэлцээтэй, алдаа мадаггүй, цаг үеэ олсон мэдээллийг эрх

бүхий байгууллага цаг тухай бүр олж авах, эдгээр мэдээлэлд нэвтрэх зохих механизмыг бүрдүүлсэн байвал зохино. Ийм алдаа мадаггүй, цаг үеэ олсон мэдээлэл нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд туйлын чухал. Хуулийн этгээдийн янз бүрийн, төрөл, хэлбэр зонхилсон нарийн төвөгтэй, ярвигтай санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд уран сэтгэмж, дүрслэн бодох өндөр ур чадвартай, бүтээлч, шаргуу, тууштай мөрдөн байцаагч нарын оролцоо шаардагддаг. Иймд хуулийн этгээдийн янз бүрийн, төрөл, хэлбэр ашигласан нарийн төвөгтэй, ярвигтай хэргийг зохих ёсоор мөрдөн шалгахын тулд санхүүгийн мөрдөн байцаагч нарт дор дурдсан асуудлаар ахисан түвшний боловсрол, мэдлэг олгох, ур чадвар дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулж байх шаардлагатай. Үүнд:

- Дэлхий даяарх хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, түүний мөн чанар, тэдгээрийг хууль бус үйл ажиллагаанд урвуулан ашиглах боломж;
- Хуулийн этгээдийн үйл ажиллагааны нарийн онцлог, “хөшигний ар” дахь нуугдмал үйл ажиллагааг таньж мэдэх хамгийн үр нөлөөтэй мөрдөн шалгах ур чадвар, арга техник, тактик.

38. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хөнгөвчлөхийн тулд улс орнууд олон нийтэд нээлттэй хуулийн этгээдийн, газрын, төрийн бус байгууллагын бүртгэл, мэдээллийн санг хөгжүүлэх шаардлагатай. Хэрэв боломжтой бол ийм бүртгэл, мэдээллийн сан нь тогтмол шинэчлэгдэж байдаг, хэзээ ч хайлт хийх бололцоотой төвлөрсөн, цахим, бодит орчинд (real time-бодит цагт) ажилладаг байх ёстой. Ийм систем нь хөрөнгө илрүүлэх, эрэн сурвалжлах, царцаах, хураан авах зорилгоор ашиглах шаардлагатай мэдээлэлд аль болох хурдтай нэвтрэх боломжийг бүрдүүлнэ.

39. Эрх бүхий байгууллагын зүгээс санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцад шаардлагатай мэдээлэл гаргуулах тохиолдолд хуулийн этгээдийн улсын бүртгэл, мэдээллийн санд хуулийн этгээдийн талаарх бүхий л үндсэн иж бүрдэл

мэдээлэл агуулагдаж байх ёстой.<sup>12</sup> Ийм үндсэн мэдээлэл нь амар хялбар аргаар шалгагдах, баталгаажих боломжтой, ямар нэгэн хоёрдмол утгагүй байх ёстой.<sup>13</sup> Улс орнууд боломжтой бол мэдээлэл хүлээж авдаг энгийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог улс орны МУТС-тэй тэмцэх дэглэмийн бүрэлдэхүүн хэсэг болох ээдрээтэй өгөгдлөөр хайлт хийдэг идэвхтэй бүртгэл, мэдээллийн тогтолцоонд шилжүүлж боловсронгуй болговол сайшаалтай. Түүнчлэн, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн санг баяжуулж буй үндсэн мэдээллийг ФАТФ-н зөвлөмжид нийцүүлэхийн тулд улс орнууд хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн санг ажиллуулахад шаардлагатай хангалттай нөөц, бололцоогоор хангах шаардлагатай. Хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээлэл, баримтыг нягтлан шалгадаг өгөгдөл ашиглах нь ашиг тустай байдаг (гол гол статистик өгөгдлүүдээр гагцхүү түүврийн аргаар ангилан ялгах зарчимд суурилсан байсан ч болно). Хуулийн этгээдийн бүртгэл, мэдээлэлд тавигдаж буй шаардлагыг биелүүлдэггүй хуулийн этгээдэд торгууль болон бусад шийтгэлийн арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх боломжтойг харуулж буй бүртгэл, мэдээллийн сан нь мэдээллийн үнэн бодит байдлыг сайжруулахад нөлөөлөх болно. Үүний үр дүнд, санхүүгийн мөрдөн байцаагч нарын хувьд тодорхой бус, хуучирсан мэдээлэл ашигладаг байсан бол өндөр чанартай мэдээлэлд шууд нэвтрэх боломжтой болно.

40. Улс орнууд хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог хөгжүүлэхийн тулд технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Хэрэв хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог МУТС-тэй тэмцэх үр дүнтэй хэрэгсэл болгохоор төлөвлөж буй бол хөгжүүлэлт, тэр дундаа үйл ажиллагааны чанарыг сайжруулах асуудлыг анхнаас нь маш нямбай төлөвлөх шаардлагатай. Ер нь цаасанд суурилсан бүртгэлээс цахим бүртгэл нь илүү зохижмтой бол хаалттай сүлжээнд суурилсан бүртгэлээс он-лайн горимд ажилладаг

<sup>12</sup> ФАТФ-н 24 дүгээр зөвлөмжийн тайлбарыг үзэх. "Ил тод байдал болон хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нар".

<sup>13</sup> АНУ Хууль Зүйн Яамны бүртгэлд байлгах мэдээллийн жагсаалтыг үзнэ үү.

бүртгэл илүү зохимжтой.

41. Улс орнууд өөрийн улсад байгуулагдсан хуулийн этгээдэд өвөрмөц ялгагдах бүртгэлийн код, дугаар өгдөг байх шаардлагатай. Ингэснээр санхүүгийн мөрдөн байцаагч нар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрөл бүрийн байгууллага, агентлагаас (тухайлбал, татвар, тусгай зөвшөөрөл олгогч, орон нутгийн байгууллага) хамгийн үр дүнтэй нотлох баримт цуглуулах боломжтой болно. Энэ нь гүйцэтгэх ажил явуулдаг байгууллагад нэн чухал байдаг. Хуулийн этгээдэд давтагдашгүй, өвөрмөц, ялгагдах бүртгэлийн код олгох үйл явц жигдэрсэн тохиолдолд улс орны хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бусад хуулийн этгээдэд (тэр дундаа, тухайн улстай ямар нэгэн аж ахуйн үйл ажиллагаагаар холбогдсон эсхүл хилийн чанадаас удирдагддаг гадаад улсын хуулийн этгээд) өгөх боломжтой.

42. Хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн компаний үндсэн мэдээлэл, тэр дундаа эцсийн өмчлөгч, түүний хяналт, банкны мэдээлэлтэй холбоотой баримтын хуулбар, тухайн компаний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулахаар итгэмжлэгдсэн этгээдэд олгосон эрх, үүргийг тусгасан баримт бичиг (итгэмжлэл) зэрэг нь тухайн хуулийн этгээдийн бүртгэлтэй хаягт хадгалагдаж байх ёстой. Ингэснээр хууль сахиулах байгууллагад нэг дороос шаардлагатай мэдээллээ олох боломж олгоно. Үүнээс гадна, ийм мэдээлэл нь тухайн улсын хуулиар үүсгэн байгуулагдсан улсын нутаг дэвсгэр дээр биетээрээ эсхүл цахим хэлбэрээр хадгалагдаж байвал зохино.



### III. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ

43. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь хоорондоо уялдаатайд тооцогддог боловч тус хоёр төрлийн гэмт хэргийн хооронд нарийн ялгагдах шинж байдаг. Эдгээр ялгагдах шинжийг санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хууль сахиулах байгууллага, санхүүгийн мөрдөн байцаагч нар ойлгодог байх ёстой. Нэг талаар, террорист байгууллага гэмт хэргийн улмаас олсон орлогоос хөрөнгө хуримтлуулахын тулд мөнгө угаах арга, техник ашигладаг бол, нөгөөтэйгүүр хууль бус үйл ажиллагаанд оролцолгүйгээр хууль ёсоор хөрөнгө хуримтлуулах олон төрлийн эх үүсвэр арга, техник ашигладаг.<sup>14</sup> Өөрөөр хэлбэл, мөнгө угаах гэдэг нь “бохир” мөнгийг “цэвэрхэн” болгож харагдуулах зорилготой үйл явц бол терроризмыг санхүүжүүлэх гэдэг нь ихэнхдээ цэвэр мөнгийг террорист ажиллагаа явуулах зорилгоор ашигладаг.

44. Терроризмыг санхүүжүүлж буй этгээд өөрийн үйл ажиллагааг хууль сахиулах байгууллагаас нуун дарагдуулах эрмэлзэлтэй байдаг. Гэмт хэрэгтний сэдэл нь террорист байгууллагын алсын хараа, хөтөлбөрийг нэн тэргүүнд ахиулан урагшлуулах үзэл санаанд тулгуурладаг. Үүний тулд ухуулга сурталчилгаа хийх, гишүүдийг элсүүлэх, террористыг томилолтоор явуулах, зэвсэг хэрэгсэл худалдаж авах зэрэг террорист байгууллагын өдөр тутмын урсгал зардал, тусгай хэрэгцээг хангах санхүүгийн эх үүсвэрийг захиран зарцуулах эрхтэй байхыг хүсдэг.

45. Террор үйлдэх гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд терроризмыг санхүүжүүлсэн эсэхийг тогтоох санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь туйлын чухал. Учир нь террор үйлдэх санаа, зорилго, сэдэл үүссэн үеэс сэжигтэн этгээдийг олж тогтоох боломжтой. Тухайлбал, гэмт үйлдлээ төлөвлөн бэлтгэхэд шаардлагатай аюулгүй орон байр сонгох явцад нь олж илрүүлэх боломжтой. Терроризмыг

<sup>14</sup> ФАТФ-н 2008 оны тайлантай танилцах. Уг тайлан террористууд хэрхэн хөрөнгө татан төвлөрүүлж, шилжүүлж, ашиглаж байгаа жишээ, баримтыг дүрслэн харуулдаг.

санхүүжүүлэх мөрдөн шалгах ажиллагааг гагцхүү нотлох баримт цуглуулах өнцгөөс харах нь өрөөсгөл бөгөөд тагнуулын нэмэлт мэдээллийн ач холбогдлыг тооцож үзэх шаардлагатай. Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцад санхүүгийн мэдээллийн ач холбогдол болон санхүүгийн мэдээлэл дунд агуулагддаг санхүүгийн бус тагнуулын мэдээ, мэдээлэл, тухайлбал, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, паспортын дугаар зэрэг мэдээллийн ач холбогдлыг харгалзан авч үзэх нь мөрдөн шалгах ажиллагааг илүү үр дүнтэй болгодог. Террорист ажиллагааг илрүүлэх, мөрдөн шалгахад тусгай албадын шугамаар авагдсан мэдээ, мэдээлэл болон санхүүгийн мэдээллийг хамтад нь харьцуулан ашиглаж буй тохиолдолд илүү үр дүнтэй. Эдгээр нэмэлт мэдээ, мэдээллийг ашигласнаар урьд өмнө илрээгүй хань, харилцааг илрүүлэх, улмаар ирээдүйд гарч болзошгүй халдлагаас урьдчилан сэргийлэхэд нөлөөлж болно.

46. Террорист халдлага үйлдэхэд их, багаас үл шалтгаалан санхүүгийн эх үүсвэр шаардлагатай. Террорист үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр олон төрөл, хэлбэртэй байдаг бол терроризмыг санхүүжүүлэхэд оролцож буй этгээдийг илүү тодорхой ангилан авч үзэж болно. Террорист ажиллагааг мөнгө, санхүүгийн эх үүсвэрээр дэмжигсдийг өөр хоорондоо уялдаа холбоотой, гүйцэтгэх үүргийн хувьд ялгаатай дөрвөн төрөлд ангилдаг. Үүнд: хандивлагч (donor), мөнгө хураагч (fundraiser), зуучлагч (facilitator), гүйцэтгэгч (operative). Гүйцэтгэх үүргийн хувьд ялгаатай боловч хоорондоо харилцан холбоотой этгээдүүдийн үйл ажиллагааг илүү ойлгомжтой жишээн дээр үндэслэн тайлбарлавал, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа бодит амьдрал дээр хэрхэн явагддагийг харж болно. Гэхдээ дээр дурдсан тодорхойлолт нь эрх зүйн тодорхойлолтод тооцогддоггүй. *Хандивлагч* гэдэгт санаатай, зориудаар эсхүл санамсаргүй байдлаар террорист байгууллагын алсын хараа, зорилго, зорилтыг санхүүгийн хандив, тусламж өгөх замаар дэмжиж буй хувь хүнийг хэлнэ. Эдгээр хувь хүн ихэнхдээ террорист

байгууллагын гишүүдтэй харилцан ажиллах нь ховор бөгөөд үйл ажиллагаа нь мөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс хэтэрдэггүй. *Мөнгө хураагч* гэдэгт террорист байгууллагын нэрийн өмнөөс уйгагүй мөнгө гуйх замаар хөрөнгө татан төвлөрүүлдэг хувь хүмүүс бөгөөд эдгээр хувь хүн ихэнх тохиолдолд мөнгө шилжүүлэх, нуун дарагдуулах үйл явцад тогтмол оролдог. *Зуучлагч* гэдэгт террорист байгууллагын удирдах бүрэлдэхүүн, гүйцэтгэгч нартай шууд харилцдаг, терроризмын зорилго, зорилтыг ухуулан сурталчлахад шууд оролцдог, террорист үйл ажиллагааны атгаг, нууц төлөвлөгөөний талаар мэдээлэлтэй хувь хүн байдаг. Эцэст нь, *гүйцэтгэгч* гэдэгт террорист байгууллагаас хуваарилсан мөнгөөр эсхүл өөрийн санхүүжилтээр шаардлагатай эд зүйлс худалдаж аван террорист халдлага үйлдэхээр бэлтгэгдсэн хувь хүнийг хэлнэ.

47. Хэдийгээр дээр дурдсан санхүүгийн дөрвөн төрлийн чиг үүргийг нэг хувь хүн (“цөөвөр чоно”) гүйцэтгэх бүрэн боломжтой ч ихэнх тохиолдолд санхүүгийн шатлан захирагдах зарчим нь зохион байгуулалттай террорист бүлэглэлийн дотоод зохион байгуулалтын хэвшмэл загварт тооцогддог. Террорист бүлэглэлд эзэлж буй хувь хүний санхүүгийн үүргийг олж тогтоох нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах оновчтой стратегийг сонгох, улмаар терроризмын мөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тасалдуулах, задлан сарниулахад туйлын чухал. Улс орнууд терроризмыг санхүүжүүлэхтэй үр дүнтэй тэмцэхийн тулд терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэгтэй хууль сахиулах болон бусад байгууллагыг тагнуулын байгууллагатай хамтран ажиллах холбогдох эрх зүйн зохицуулалт, механизм бий болгох шаардлагатай. Улс орнууд өөр өөр чиг үүрэгтэй байгууллагыг терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нийтлэг эрх ашгийн төлөө хамтдаа тэмцэх таатай орчин, нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай.

48. Террорист халдлагын үед (тухайлбал, олон хүн хүндээр шархдаж, хүний амь нас хохирсон дэлбэрэлтийн үед) терроризмын халдлагыг санхүүжүүлсэнийг террорист үйл ажиллагаа явуулсантай хамтатган мөрдөн шалгах хэрэгтэй.

Учир нь террорист халдлагыг санхүүжүүлсэн үйл ажиллагаа нь террорист бүлэглэлийн үйл ажиллагааны бүхий л мөчлөгийг харуулсан салшгүй хэсэг. Мөрдөн шалгах зэрэгцээ ажиллагаа нь төрөл бүрийн эрх бүхий байгууллага хоорондын харилцааг бэхжүүлээд зогсохгүй эрх бүхий байгууллага, санхүүгийн салбар, санхүүгийн хянан шалгагч, зохицуулагч нарын хоорондын ажил хэргийн харилцааг сайжруулдаг. Ийм харилцаа нь зөвхөн хадлагын дараах мөрдөн шалгах ажиллагаанд бус, харин террорист халдлагыг төлөвлөх, бэлтгэх үе шатанд террористын санхүүгийн ул мөрийг олж тогтоох чадамжийг өргөтгөх, санхүүгийн тагнуулын оролцоог нэмэгдүүлэх илүү цогц барилыг хөхиүлэн дэмждэг ач холбогдолтой. Ингэснээр террорист халдлагаас урьдчилан сэргийлэх, хүний амь нас хохирохоос зайлсхийх нийтлэг зорилгод хүрэх боломжтой болдог. Олон нийт, санхүүгийн салбар болон эрх бүхий байгууллага тагнуулын мэдээллийн буюу мэдээллийн ажлын эцсийн бүтээгдэхүүний чухал бүрдэл хэсгийг бий болгох мэдлэг, мэдээлэлтэй байдаг. Мөн түүний нэгэн адил, хянан шалгалт, зохицуулалтын болон эрх бүхий байгууллага мэдээллийн ажлын эцсийн бүтээгдэхүүн болох тагнуулын мэдээллийг нэгтгэхэд шаардлагатай дүрэм, журам боловсруулах боломжтой.

## IV. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

49. Санхүүгийн мөрдөн байцаагч нар өөрсдийн эрх хэмжээний хүрээнд байгаа мэдээлэлд таамаглал дэвшүүлж, дүгнэлт гаргадаг. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь сэжигтний санхүүгийн будлианыг мөрдөн шалгахын тулд шалгарсан, туршигдсан мөрдөн шалгах ажиллагааны арга, техник, уламжлалт нягтлан бодох бүртгэл, аудитын практик ур чадвар, арга барилын нийлбэрээс бүрддэг. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд хамааралтай баримт, материал төрөл бүрийн эх сурвалжаас олдож болно. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд үйл явдлын бүрэн зураглал, нөхцөл байдлыг уламжлалт аргаар тогтоох нь мэдээж туйлын чухал ба түүний дотор сэжигтэнтэй биечилсэн сурвалжлага хийх, тайлбар, байцаалт авах, оршин суугаа орон байр эсхүл албан байранд үзлэг, нэгжлэг хийх, компьютерийн мэдээлэлд шүүхийн шинжилгээний аргаар үзлэг, баримтжуулалт хийх, санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны баримт бичиг, тайлан бүртгэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх, тэр дундаа банкны дансны хуулга, татварын мэдүүлэг гаргуулах гэх мэт.

50. Дэвшүүлсэн таамаглалын мөн чанар, шинж чанар нь таамаглалыг шалгахын тулд ямар төрлийн мэдээлэл шаардлагатай болохыг ихэнхдээ тодорхойлж өгдөг. Санхүүгийн мөрдөн байцаагч нь шаардагдаж буй мэдээллийн төрлийг ойлгож, ялгаж танихаас шалтгаалан тухайн мэдээлэл хаана хадгалагдаж байгааг олох боломж олгодог. Шаардлагатай мэдээллийн байршил тодорхой болмогц мэдээллийг хэрхэн, ямар арга замаар олж авах, мэдээллийг олох явцад ямар хүндрэл, бэрхшээл тулгарч болзошгүйг тодорхойлох хэрэгтэй. Ингээд санхүүгийн мөрдөн байцаагч нар мэдээллийг амжилттай олж авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах бөгөөд ийм төлөвлөгөөнд энэхүү зөвлөмжид дурдагдсан мөрдөн шалгах ажиллагааны олон арга, техник багтаж болно.

51. Мэдээллийн эх сурвалжийг тодорхойлсны дараа нотлох баримтыг цуглуулах шаардлагатай. Эх сурвалжаас үл

шалтгаалан мөрдөн байцаагч бүх нотлох баримтыг хуулийн дагуу олж авах ёстой. Нотлох баримтыг хуулийн дагуу олж аваагүй тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхэд шилжүүлсэн хэрэгт шүүхийн шийдвэр гаргуулах, хөрөнгө хураахад эргэлзээтэй байдал бий болгоно. Мөрдөн байцаагч нар нотлох баримт цуглуулахдаа хуулийн дагуу олгогдсон бүхий л давуу эрх, эрх хэмжээгээ сайтар мэддэг байх шаардлагатай бөгөөд прокурор болон бусад холбогдох эрх бүхий байгууллагаас зөвлөгөө авч, хамтран ажилладаг байх хэрэгтэй. Тэр ч байтугай, зарим мэдээ, мэдээлэл прокурорын байгууллагын хувьд боломжит нотлох баримт мэт үнэлэгдэж болох ч, нөгөөтэйгүүр, гүйцэтгэх ажил, тагнуулын үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хувьд тагнуулын эмзэг мэдээ, мэдээлэлд тооцогдож болно. Тиймээс, прокурорын байгууллага болон тагнуулын байгууллага хоорондоо харилцан уялдаатай ажиллах шаардлагатай.

### **МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ, ТӨРӨЛ**

52. Мөрдөн шалгах чиг үүрэгтэй эрх бүхий байгууллагаас төрөл бүрийн мэдээлэл олж авч ашиглах боломж улс орон бүрт харилцан адилгүй. Мэдээллийн хүртгэмжтэй байдалд хуульд заасан зарим шаардлага, тэр дундаа хүний эрхийг хангахтай холбоотой асуудал (мэдээллийн эрх чөлөө, хувь хүний нууцлалын тухай хууль тогтоомж)-ууд нөлөөлдөг. Төрөл бүрийн мэдээлэл болон мэдээлэл дүн шинжилгээний ажлын эцсийн бүтээгдэхүүний зохиогч, эзэмшигч нар улс орон бүрт өөр өөр байдаг. Түүнчлэн, ийм мэдээ, мэдээлэлд ямар нөхцөл, журмын дагуу нэвтрэх нь МУТС-тэй тэмцэх эрх зүйн болон үйл ажиллагааны үр дүнтэй тогтолцоо бүрдүүлж буй улс орнуудын хувьд нэг төрлийн саад тотгорт тооцогддог. Мэдээллийн аюулгүй байдлын болон хувь хүний халдашгүй байх эрх, эрх чөлөөг хамгаалж буй хууль тогтоомжийн биелэлтийг хангах зорилгоор эрх бүхий байгууллагаас хувь хүний нууц мэдээлэлд нэвтрэх эрх олж авах, ийм мэдээллийг удирдахын тулд өөрийн ажилтнуудыг зохих түвшинд бэлтгэх шаардлагатай.

53. Энэхүү зөвлөмжид санхүүгийн мөрдөн шалгах, эрүүгийн

хэрэг шалган шийдвэрлэх, хөрөнгө хураах зорилгоор хөрөнгө олж тогтоох ажиллагааг дэмжихэд тагнуулын мэдээ, мэдээлэл ямар хэмжээнд нээлттэй, хүртээмжтэй болохыг юуны өмнө судлан авч үзэж байна. Хууль сахиулах байгууллага санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахын тулд өргөн хүрээтэй төрөл бүрийн санхүүгийн, захиргааны болон хууль сахиулахын мэдээлэлд нэвтрэх эрх хэмжээтэй байх хэрэгтэй. Ийм мэдээлэлд нээлттэй болон олон нийтийн эх үүсвэрээс гаралтай мэдээлэл хамаарахын зэрэгцээ, бусад төрийн байгууллагаас ирүүлэх боломжтой эсхүл тухайн байгууллагын хүсэлт, даалгавраар гаргуулах боломжтой мэдээлэл байна. Шаардлагатай тохиолдолд хувийн хэвшлийнхэнд хадгалагддаг аж ахуйн үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл хамаарна.

54. Мэдээллийн төрөл, хэлбэр нь цаасан баримт, сэлтээс эхлээд цахим мэдээлэл болон биет эд зүйл хүртэл нэлээд олон янз байдаг. Янз бүрийн мэдээллийг өмчлөх эрх, тэдгээрт тавих хяналтын зэрэглэл бүр хоорондоо ялгагддаг. Нэг талаас, хууль сахиулах байгууллага нэвтрэх эрхтэй ихэнх мэдээлэл нь олон нийтэд нээлттэй мэдээлэл байдаг ба чөлөөтэй ашиглах боломжтой. Нөгөөтэйгүүр, хувь хүний, санхүүгийн эсхүл хууль сахиулах байгууллагын бүртгэл, мэдээлэл нь хамгаалагдсан байдаг бөгөөд ихэнх тохиолдолд нууцлал өндөртэй, нууцлагдсан байдаг. Ийм төрлийн мэдээлэл нь урвуулан ашиглагдахаас хамгаалагдсан эсэх, хууль ёсны үндэслэл, журмын дагуу нэвтэрч байгаа эсэх, хуулийн хүрээнд, хууль ёсны зорилгоор ашиглагдаж байгаа эсэхэд тус тус баталгаа байх шаардлагатай.

55. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллага болон эрх бүхий бусад байгууллагын ашиглаж болох мэдээллийг эх сурвалж өөр хоорондоо ялгаатай бөгөөд дор дурсан 6 төрөлд хувааж болдог:

- **Эрүүгийн тоо бүртгэл, тагнуулын мэдээ, мэдээлэл.** Үүнд гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт үйл ажиллагаатай холбогдолтой хууль сахиулах үйл ажиллагааны талаарх мэдээлэл

хамаарна. Тухайлбал, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж байсан тухай, урьд өмнө нь ял шийтгэл эдэлж байсан тухай, яллах тогтоол, түүнчлэн “эрүүгийн ертөнц” дэх онц аюултай гэмт этгээдтэй харилцаа холбоотой эсэх тайлан, бүртгэл, мэдээ байж болно. Гэмт хэргийн шинжтэй мэдээллийг гүйцэтгэх ажлын нууц ажиглалтын арга хэмжээ, нууц мэдээлэгч, биечилсэн сурвалжлага, байцаалт, мэдээллийн дүн шинжилгээ эсхүл хамгийн хялбараар цагдаагийн ажилтнуудын тусламжтай “гудамж”-с олох боломжтой мэдээлэл байна;

- **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үйл ажиллагааны үр дүн.** Санхүүгийн Мэдээллийн Албаны сэжигтэй гүйлгээний тайлангаас гадна хуульд заасны дагуу шаарддаг мэдээллүүд хамаарна. Тухайлбал, улсын хилээр орсон, гарсан бэлэн мөнгөний тайлан, бэлэн ба бэлэн бус мөнгөний шилжүүлгийн тайлан эсхүл хуульд заасан босго дүнгээс хэтэрсэн мөнгөн шилжүүлгийн тайлан, мэдүүлэг;
- **Санхүүгийн мэдээлэл.** Үүнд хууль сахиулах байгууллага, тусгай албадын сонирхол татаж буй аж ахуйн нэгжийн санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл хамаарах ба ийм мэдээлэл нь аж ахуйн үйл ажиллаганы мөн чанар, эх үүсвэр, нөөц бололцоо, бүтэц, чадамжийн талаар ойлголттой болох, түүнчлэн ирээдүйд болох үйл явдал, үйл ажиллагааг урьдчилан таамаглах, хөрөнгийн байршлыг олж тогтооход тусалдаг. Ийм төрлийн мэдээлэл нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны үр дүнд олж авдаг мэдээллийн хүрээ, хязгаараас давах ба ихэнхдээ гуравдагч этгээд - хувь хүн, хуулийн этгээдийн эзэмшилд байдаг. Ийм мэдээлэлд банкны



дансны хуулга, санхүүгийн тайлан, мэдээлэл, бусад хувийн шилжүүлэг, эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой гүйлгээ, түүнчлэн, харилцагчийг зохих ёсоор таньж мэдэх, шалгах үүргийг биелүүлэх явцад авагдсан мэдээ, мэдээлэл хамаарна;

- **Нууц мэдээлэл.** Энэ төрлийн мэдээлэлд үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор цуглуулдаг мэдээлэл хамаарна. Үүнд, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл орно. Ийм төрлийн мэдээлэлд гол төлөв хуулийн дагуу тодорхой бүлэг хүмүүс л нэвтрэх хязгаарлалт тогтоосон байдаг;
- **Нээлттэй эх үүсвэр.** Энэ төрөлд интернет, олон нийтийн сүлжээ, хэвлэмэл болон цахим олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, түүнчлэн нээлттэй болон хаалттай бүртгэлийн систем хамаарна;
- **Хяналт шалгалт, зохицуулалтын байгууллагын мэдээлэл.** Ийм төрлийн хяналт, зохицуулалтын байгууллагын мэдээллийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглах хязгаарлалт тогтоосон байдаг. Энэ ангилалд төв банк, татвар, гаалийн байгууллага болон бусад төсвийн орлого бүрдүүлэгч агентлагийн эзэмшилд байдаг мэдээлэл хамаарна.

56. Хамтарсан ажлын хэсэг, зорилтот бүлэг (зөвлөмжийн 2 дугаар хэсэгт дурдагдсан) нь урьд өмнө зохион байгуулалтын болон техникийн шалтгаанаар тусгаарлагдмал байсан хууль сахиулах болон тусгай албадын мэдээллийн эх сурвалжаас авагдсан мэдээллийг нэгтгэх үүрэг гүйцэтгэдэг. Зарим улс оронд ийм нэгдмэл зохион байгуулалтад оруулахын тулд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний актад өөрчлөлт оруулах эсхүл харилцан ойлголцлын санамж бичиг зэрэг албан ёсны гэрээ, хэлцэл байгуулдаг. Эдгээр ажлын хэсэг, зорилтот бүлэг нь төрөл бүрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, байгууллага хоорондын мэдээллийг нэгтгэхийн тулд

ажиллагаанд байгаа технологийг бүрэн гүйцэт ашиглах, шинэ технологи хөгжүүлэх хөшүүрэг болдог. Нэн ялангуяа эдгээр мэдээлэл нь төвлөрсөн, нэгдмэл мэдээллийн санд хадгалагддаг бөгөөд хамтарсан ажлын хэсэг нь ирээдүйд явуулах мөрдөн шалгах ажиллагааны шинэ объект буюу сэжигтнийг мэдээллийн санд байгаа мэдээлэлтэй давхцаж буй эсэх талаас нь шалгах боломжтой.

## **V. ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГА БА САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА (СМА) ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

57. СМА нь хууль сахиулах байгууллага болон эрх бүхий бусад байгууллагын гүйцэтгэх ажил эрхэлдэг салбар, нэгжтэй нэгэн адил санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг санаачлан эхлүүлэх, түүнийг чанартай, үр дүнтэй болгоход нөлөөлдөг эрх бүхий байгууллага мөн. Хууль сахиулах байгууллага, СМА-нд болон эрх бүхий бусад байгууллагын цуглуулсан санхүүгийн мэдээлэл нь сайтар боловсруулалтад орж, санхүүгийн угтан мөрдөн шалгах ажиллагаанд бэлтгэхэд ашиглагдах учиртай. СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс цуглуулдаг мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнг эрх бүхий хууль сахиулах байгууллага болон тусгай албанд хуваарилах үндсэн үүрэгтэй. СМА-ны дүн шинжилгээний чадавх нь мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд ач тустай, ажлыг нь хөнгөвчлөх төрөл бүрийн тагнуулын мэдээллийн шинжтэй бүтээгдэхүүн бий болгодог. СМА нь тогтсон журмын дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй сэжиг, хардлага агуулсан мэдээллийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагад өөрсдийн санаачлагаар дамжуулдаг. Дамжуулсан мэдээлэл нь хууль сахиулах байгууллагын боловсруулалтад орж, тэдгээрийн сонирхол татаж буй хуулийн этгээдийн тухай, мөрдөн шалгах ажиллагаа явагдаж буй хэрэгт дэмжлэг үзүүлэх тухай, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын шугамаар авагдсан шинэ мэдээлэлд үндэслэн угтан мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх тухай мэдээлэл тус тус хамаарч болно.

### **САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА БА МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙГ САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ИЛ БОЛГОХ НЬ**

58. Урагштай, үр дүнтэй санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь хууль сахиулах байгууллагын зүгээс СМА-ны мэдээллийн

бүтээгдэхүүнийг өргөн хүрээнд, далайцтай ашиглах, мэдээлэл болон мэргэжилтэн, шинжээчдээ солилцох зэрэг үндсэн шинжээр тодорхойлогдоно. Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах үедээ СМА-ны мэдэлд байдаг мэдээллийг гаргуулах хүсэлт тавих боломжтой. Өөрөөр хэлбэл, ийм орчин, нөхцөлд ажиллах боломжийг бүрдүүлсэн байна. СМА-д ФАТФ-н 31 дүгээр зөвлөмжид заасны дагуу эрх бүхий байгууллагын хүсэлтэд хариу өгөх чадамжтай байх ёстой. ФАТФ-н 29 дүгээр зөвлөмжийн тайлбарт заасны дагуу эрх бүхий байгууллагаас СМА-дад хүргүүлсэн хүсэлтийн хариуд ямар мэдээлэл өгөх эцсийн шийдвэрийг зөвхөн СМА нь өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэнэ.

59. СМА болон мөрдөн шалгах эрх бүхий байгууллага нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн тулд зохих ёсоор мэдээлэл солилцон, нэгдмэл, баг болж ажиллах нийтлэг зарчмыг нэн тэргүүнд эрэлхийлэх ёстой. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь СМА-ны санхүүгийн дүн шинжилгээний үр дүнг олж авч ашиглах, түүнчлэн СМА болон мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын хооронд идэвх, санаачлагатай мэдээлэл солилцох замаар амжилттай болж, үр дүнд хүрдэг. Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага өөрт хэрэгцээтэй мэдээлэл буюу тэргүүлэх зорилтоо СМА-нд танилцуулж ойлгуулснаар тус алба нь хэрэгцээтэй мэдээллийг үйл ажиллагааны явцад аяндаа олж тогтоон цаг алдалгүй шилжүүлэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой. Олон тооны мөрдөн шалгах эрх бүхий байгууллага СМА-тай нягт хамтран ажиллах, үр дүнтэй мэдээлэл солилцох ажлыг хялбаршуулахын тулд СМА-нд өөрсдийн ажилтнуудаа томилон ажиллуулж байгаагийн зэрэгцээ СМА-ны ажилтнууд мөн мөрдөн шалгах эрх бүхий байгууллагад ажилтан, шинжээчээ ажиллуулж байна. Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага болон СМА-ны ажилтнуудын хооронд үүссэн ажлын харилцаа нь тууштай, үр дүнтэй мэдээлэл солилцоход нөлөөлдөг.

60. Эрх бүхий байгууллага болон СМА-д хэрхэн харилцан хамтран ажиллах, ямар мэдээлэл солилцооны суваг ашиглах

талаарх хэлэлцээр, тохироог албан ёсны баримт бичигт тусгаж албажуулснаар зохих ёсоор мэдээлэл солилцох ажиллагаа, түүний журам, дэс дарааллыг илүү ойлгомжтой болгож өгдөг. СМА болон мөрдөн шалгах эрх бүхий байгууллагад хооронд аюулгүй зам сувгаар солилцох цахим тайлан, мэдээлэл, мэдээллийн лавлагаа, хүсэлтийн тогтсон стандарт хэлбэр ашиглах тухай асуудлыг тохиролцох нь үр дүнтэй мэдээлэл солилцоход эерэгээр нөлөөлдөг. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой их хэмжээний мэдээлэл (тухайлбал, дүн шинжилгээний үр дүн агуулсан цахим файл) дамжуулах тохиолдолд эрх бүхий байгууллагууд болон СМА-ны ашиглаж буй програм хангамжийн зохицолдоог тооцож үзэх шаардлагатай. Зарим улс орон мөрдөн шалгах эрх бүхий байгууллагад СМА-ны мэдээллийн санд нэвтрэх хязгаарлагдмал эрх олгодог. Ингэснээр мөрдөн байцаагч нар тодорхой зөвшилцөл, тогтсон журмын дагуу мэдээллийн лавлагаа авахаар СМА-ны мэдээллийн санд шууд хандах боломжтой болдог. СМА-ны мэдээллийн санд мөрдөн байцаагч нар нэвтрэх эрх олгох асуудлыг зохицуулах явцад нууцлал, хүний эрх, хувь хүн, байгууллагын нууцлал, мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг харгалзан үзвэл зохино.

## **ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГААС МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ИЛ БОЛГОСОН МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ БОЛОН САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ.**

61. Энэхүү зөвлөмж СМА-ны чиг үүргийг дөвийлгөөгүй ч СМА нь дээд зэргийн чанартай, хэрэгтэй, цаг үеэ олсон дүн шинжилгээний бүтээгдэхүүн (мэдээлэл)-р хууль сахиулах байгууллага болон эрх бүхий бусад байгууллагыг хангах боломжтой гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Ийм дээд зэргийн чанартай, цаг үеэ олсон мэдээллийн бүтээгдэхүүн бий болгохын тулд гагцхүү СМА болон мэдээлэл хүлээн авагч бүх талын хооронд эргэх холбоотой хоёр талт механизм ажилладаг байх шаардлагатай.

62. МУТСТ үйл ажиллагааны санхүүгийн тайлан, мэдээлэл, СМА-ны мэдээлэл дүн шинжилгээний бүтээгдэхүүн нь үндэсний МУТСТ тогтолцооны хүрээнд хуримтлагддаг онцгой зэрэглэлтэй мэдээллийн эх сурвалжид тооцогддог. Энэ төрлийн мэдээлэл нь хууль сахиулах байгууллага, тэр дундаа санхүүгийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг мэргэшсэн мөрдөн байцаагч нарт зориулагдсан байдаг. Мэдээлэх үүрэгтэй этгээд МУТСТ тухай хууль тогтоомжийн дагуу МУТСТ үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тайлагнах үүрэгтэй. Эдгээр мэдээлэлд СГТ (сэжигтэй гүйлгээний тайлан) болон МУТСТ тухай хуулийн дагуу шаарддаг бэлэн ба бэлэн бус мөнгөн гүйлгээний тайлан, босго дүн бүхий мэдүүлэг, тайлан, бэлэн валют, төлбөрийн хэрэгслийг хил дамнуулан биетээр тээвэрлэсэн тухай тайлан мэдүүлэг хамаарна.

63. МУТСТ үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээлэл нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд онцгой үнэ бүхий мэдээллийн эх сурвалжид тооцогддог. Иймд СГТ-н ашиглалтанд онцгой ач холбогдол өгөхийн зэрэгцээ түүний хосгүй мөн чанарыг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Ихэнх улс орон СГТ-г гүйцэтгэх ажил, тагнуулын зорилгоор ашигладаг бөгөөд шүүхийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд ашигладаггүй. Зарим улс оронд СГТ-г бүхэлд нь шүүхийн шатанд нотлох баримтын хэмжээнд ашигладаг тохиолдол байдаг бөгөөд ийм нөхцөл байдал хоёр өөр эрх зүйн тогтолцоотой улс орны хооронд үүсвэл улс орнууд мэдээллийг үр дүнтэй ашиглах таатай нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр ажлаа уялдуулж дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Түүнчлэн, энэ төрлийн мэдээлэлд нэвтрэх, ашиглахтай холбоотой харилцаанд нууцлалыг чандлан хамгаалах асуудлыг харгалзан үзэх шаардлагатай. Ийм төрлийн мэдээлэлд зөвхөн зохих ёсоор бэлтгэгдсэн, эрх бүхий хууль сахиулах байгууллагын ажилтан нэвтрэх эрхтэй байх нь туйлын чухал.

64. СМА-ны мэдээлэлд үндэсний болон олон улсын түвшинд нэвтрэх зохицуулалтын механизмыг хэрхэн зохион байгуулснаас хамаарч гүйцэтгэх ажил, тагнуулын

ач холбогдолтой мэдээ, мэдээлэлд гүйцэтгэх ажил явуулдаг эрх бүхий байгууллага ямар түвшинд нэвтрэх, тухайн мэдээллийг ямар түвшинд нотлох баримтын хэмжээнд ашиглаж болохыг тодорхойлоход чухал байдаг. Цаг үеэ олсон мэдээлэл солилцооны урсгалыг бүрдүүлэхийн тулд СМА-с мэдээлэл солилцооны эхний үе шатанд хууль сахиулах эрх бүхий байгууллага руу шилжүүлсэн мэдээлэлтэй харьцах талаар ойлгомжтой, зааварчилгаа, анхааруулга өгч болох бөгөөд аажимдаа шаардлагатай тохиолдолд бусдад дамжуулах урьдчилсан зөвшөөрөл өгч болно. Хувь хүний нууц, халдашгүй эрхийг хамгаалахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх, хууль ёсны үндэслэл, журмын дагуу санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллагатай хуульд нийцсэн, зохих ёсны мэдээлэл солилцох нөхцлийг бүрдүүлэхийн тулд мэдээллийг бусдад дамжуулах, ил болгох асуудлаар СМА-тай харилцан зөвшилцөж болно. Хэрэв урьдчилсан байдлаар (гуравдагч талын журам гэгдэх) зөвшөөрөл авах шаардлагатай бол ийм зөвшөөрлийг цаг алдалгүй, их хугацаа зарцуулалгүй авч болох механизмыг СМА-д бүрдүүлэх шаардлагатай. Улс орнуудын сэжигтэй гүйлгээний тайлантай харьцаж ажилладаг янз бүрийн практик арга барил, хандах хандлагаас шалтгаалан улс орон бүрийн онцлогт тохирох СГТ-г ашиглах чиглэлээр нарийн загвар, жишээ байдаггүй. Үүнээс үл хамааран улс орнууд СМА-ны мэдээлэл болон дүн шинжилгээний бүтээгдэхүүн, үр дүнг мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүднээс цаг тухайд нь дамжуулах боломжтой механизмыг бий болгох шаардлагатай. Мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг ойлгомжтой, нарийн журамлах ёстой бөгөөд мэдээллийн зохих ёсны ашиглалт, аюулгүй байдлыг хангах үүднээс шаардлага хангахуйц хамгаалалтын механизм бий болгох хэрэгтэй. Мэдээлэл солилцох, дамжуулах аливаа механизм нь мэдээллээ бүртгэдэг, хянадаг системтэй байх ёстой байхын зэрэгцээ мэдээллийг ямар нэгэн саадгүйгээр гаргуулж байх нөхцлийг бүрдүүлсэн байх ёстой. Аливаа нөхцөлд мөрдөн байцаагч нар мэдээлэлтэй харьцаж ажиллахдаа нууцлал хангахтай холбоотой шаардлагыг чандлан мөрдөх, хүний эрх, хувь хүний

нууц, мэдээ, мэдээллийг хамгаалах үүрэгтэй.

### **САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААГ ЧАНАРЖУУЛАХ ЗОРИЛГООР САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ МЭДЭЭЛЭЛ ГАРГАХ ЧАДАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ**

65. Энэхүү зөвлөмжийн энэ хэсэг нь СМА-ны үйл ажиллагаа хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай харилцан уялддагийг нотлохыг зорьж байгаа бөгөөд санхүүгийн тагнуул нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг чанаржуулахад үргэлж бэлэн байдгийг онцлон тэмдэглэх зорилготой. Мөнгө угаахын суурь гэмт хэрэг болон санхүүгийн үр шим хүртэхэд чиглэсэн аливаа гэмт хэргийг мөрдөн шалгахад Санхүүгийн Мэдээллийн Албатай холбоотой бүхий л мэдээллийг гаргуулах хүсэлт тавих нь тогтмол хийгдэх ажлуудын нэг байх ёстой. Мөрдөн байцаагч нь энэ үе шатанд хийгдэх ажиллагааг мөрдөн байцаах ажлын төлөвлөгөө эсхүл хийж гүйцэтгэх ажлын хяналтын хүснэгтэнд тусгадаг байх хэрэгтэй. Энэ нь улсын хэмжээнд бүртгэгдэж буй МУТСТ ажиллагааны мэдээлэлд хууль сахиулах байгууллагууд цаг тухай бүр нэвтрэх боломжтой байх шалтгааны нэг юм. Өмнө дурдасны дагуу, хууль сахиулах байгууллагууд мэдээлэлд шууд нэвтэрдэг байх албагүй ч чухал, ач холбогдолтой мэдээллийг нэгтгэх явдлыг хялбаршуулах, ажиллагаанд байгаа хэргийн мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх зорилгоор шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь гаргуулах боломжтой байх хэрэгтэй.

66. СГТ-д агуулагдаж буй мэдээллийг Санхүүгийн Мэдээллийн Албаны мэдээллийн санд өмнө нь авагдаж байсан мэдээлэлтэй тулган нягтлах тохиолдолд угаасан мөнгө, террорист ажиллагаа явуулахад зориулагдсан хөрөнгийг олж илрүүлэхэд туслах замаар МУТС-тэй холбоотой мөрдөн шалгах ажиллагааны цар хүрээг өргөтгөх боломжтой. СГТ нь мөрдөн байцаагч нарт бусад салангид, тасархай мэдээллийг хооронд нь холбоход туслах, гэмт үйл ажиллагааны орлого эсхүл террорист ажиллагаа явуулахад зориулагдсан хөрөнгийн байршил, шилжүүлсэн хөрөнгийн хөдөлгөөнийг олж тогтоох сэжүүрийг өгөх, тэр ч байтугай шилжүүлэхдээ



ямар арга ашигласныг олж мэдэх боломжтой. СГТ-г гэмт хэрэгт буруутгах үндэслэл болгох эсхүл гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн нэгэн адил авч үзэх ёсгүй. Гэхдээ, ихэнх тохиолдолд СГТ-д агуулагддаг санхүүгийн үйл ажиллагаа тэр дундаа чекийн, картын, зээлийн залилан, хуурамч мөнгө тэмдэгт үйлдвэрлэх, хөрөнгө завших, үрэгдүүлэх, хуульд заасан босго хэмжээтэй гүйлгээг мэдээлэх үүргээс зайлсхийх зорилгоор гүйлгээг олон хэсэгт хэсэгчлэн хуваан байршуулах, шилжүүлэх зэрэг үйлдэл нь хууль бус юм.

67. СМА-д мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын хүсэлтийн хариуд шаардлагатай мэдээлэл шилжүүлэх замаар мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн туслалцаа үзүүлж болно. Энэ мэдээлэл нь гэмт хэргийн улмаас олсон орлогыг илрүүлэх, байршлыг тогтоох, түүнчлэн яллах шүүхийн тогтоол гаргуулах, хөрөнгө улсын орлого болгох зэрэг идэвхтэй ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. СМА нь мөрдөн шалгах ажиллагааны чанар, үр дүнг дээшлүүлж болох өөрийн нөөц, бололцоо болон гуравдагч этгээд (дотоод болон гадаад)-с хүлээн авсан, цуглуулсан мэдээлэлтэй байдаг. Зарим мэдээлэл нь нууцлалын өндөр зэрэглэлтэй, нууц байх бөгөөд бусдад шилжүүлэх тохиолдолд тодорхой хязгаарлалт үйлчилнэ. Мэдээлэлд тавигдах хязгаарлалтыг хуулиар эсхүл мэдээллийг эзэмшигч гуравдагч этгээд тогтооно. СМА-с хүлээн авсан мэдээлэлд ямар төрлийн хязгаарлалт тавигдаж байгааг мөрдөн байцаагч нар анзаарах, тэр тусмаа мөрдөн шалгах ажиллагаанд хэрхэн, ямар байдлаар ашиглах талаар онцгой анхаарах шаардлагатай. Хууль сахиулах байгууллагын энэ төрлийн мэдээлэлтэй харьцаж буй албан хаагч нь мэдээлэл ил болох, задрахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн холбогдох хууль, журамтай танилцсан, бэлтгэгдсэн, мэдлэгтэй байх нь чухал.

### **СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН БОЛОН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД МЭДЭЭЛЭЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

68. СГТ болон МУТС тэмцэхтэй холбоотой бусад мэдээллийг бусад төрлийн эх сурвалжаас авсан мэдээлэлтэй харьцуулахад

ихэнх тохиолдолд санхүүгийн мөрдөн байцаагч нар нөхцөл байдлын зураглалыг илүү ойлгож эхэлдэг. СГТ-д дараагийн шатны дүн шинжилгээг бусад мэдээллийн эх сурвалж, бусад СГТ, бэлэн ба бэлэн бус мөнгөний тайлан, түүнчлэн ил ба далд мэдээллийн эх сурвалжаас авсан мэдээлэлтэй харьцуулан үргэлжлүүлэн хийхэд (СГТ-н анхны үнэлгээг СМА өгдөг) тухайн мэдээллийн жинхэнэ үнэ, цэнэ, ач холбогдол нь өсдөг. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд СГТ дахь мэдээллийг үр дүнтэй ашиглахын тулд СГТ-д агуулагдаж буй мэдээллийг хууль сахиулах байгууллагын эрх хэмжээний хүрээнд авагддаг мэдээлэлтэй харьцуулах нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үндсэн нөхцөл байх ёстой. Хууль сахиулах байгууллага болон СМА нь ямар төрлийн шалгах ажил явуулсан, ил болгож буй МУТС тэмцэх мэдээлэл, тайлангийн аль хэсэг нь мөрдөх шалгах ажиллагааг үргэлжлүүлэхэд илүү сонирхол татаж байгааг талууд харилцан ойлгохыг эрмэлзэх замаар хамтран ажиллахыг зорих нь туйлын чухал байдаг.

69. СГТ дахь мэдээлэлд урьдчилсан байдлаар үнэлгээ хийхдээ хууль бус ажиллагаа, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаар эрүүгийн тагнуулын, эрүүгийн тоо бүртгэлийн, шалгагдаж буй эсхүл өмнө нь ямар нэгэн хэрэгт холбогдолтой байсан эсэх мэдээллийн сан, зарим тохиолдолд хөрөнгө, татварын мэдээллийн сангаар өргөтгөн шалгах, судлахаар ялгаж шигшсэн сэжигтэй гүйлгээний тайлангуудад түүврийн арга ашиглах шаардлагатай. Урьдчилсан байдлаар ийм арга барил ашиглах нь үргэлжлүүлэн шалгах шаардлагатай СГТ-г тодорхойлох ажлын нэг хэсэг бөгөөд аль хэдийнэ шалгах ажиллагаанд байгаа эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд сонирхлын зөрчил үүсгэхээс зайлсхийх боломжийг бүрдүүлдэг.

70. Хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй ашиглах шаардлага нь ихэнх мөрдөн байцаагчид тулгамдсан зорилтын нэг билээ. Шаардлагатай тохиолдолд СГТ-г ач холбогдол, мөрдөн шалгах ажиллагааны тэргүүлэх зорилт, улс орны гэмт хэрэгтэй тэмцэх стратегид үндэслэн эрэмбэлж ангилах хэрэгтэй. Сар бүр их хэмжээний СГТ хуримтлагддаг зарим улс оронд туршлагатай, өндөр хэмжээнд бэлтгэгдсэн ажилтныг СГТ-н

анхан шатны дүн шинжилгээний ажилд татан оролцуулж болно. Урьдчилан боловсруулсан шалгуур, өгөгдлийг харгалзан ийм төрлийн анхан шатны дүн шинжилгээ хийснээр хууль сахиулах байгууллагын онцгой анхаарал татах СГТ-г илрүүлэх боломжтой. Тухайлбал, их хэмжээний мөнгийг олон хэсэгт бутлах замаар хуульд заасан босго дүнгээс доогуур шилжүүлэг хийсэн үйлдэл (structuring) эсхүл хууль бус мөнгөн шилжүүлгийн үйл ажиллагаа байж болно. Ийм арга барил ашигласнаар шалгах, үнэлэх СГТ-н хүрээ хумигдаж мөрдөн байцаагч нарын сонирхол татахааргүй СГТ ялган тусгаарлагддаг. СМА-д хэрэгцээтэй байгаа мэдээллийн шаардлагыг нарийвчлан эрэмбэлж өгвөл СМА-ны хувьд хэрэгцээтэй мэдээллийг төвөггүй үр дүнтэй олж ялгах, улмаар хууль сахиулах байгууллагад өөрсдийн санаачлагаар шууд шилжүүлэхэд дөхөмтэй байдаг. Энэ бүхнээс өөрт буй нөөц, бололцоогоо үр дүнтэй хуваарилахад СМА болон хууль сахиулах байгууллагууд хоорондоо нягт мэдээ, мэдээллээ солилцож байх шаардлагатай гэдгийг харж болохоор байна.

71. Мэдээллийн эх сурвалж болон мэдээллийн төрөл гэсэн хэсэгт дурдагдсан МУТС тэмцэхтэй холбоотой бусад мэдээлэлтэй холбогдуулан ийм төрлийн мэдээллийг улс орнууд СМА-д болон санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллагад төвөггүй гаргуулах боломжтой байх нөхцлийг нууцлалын шаардлага, хүний эрхийг хамгаалах, хувь хүний болон мэдээллийн нууцыг хамгаалах зэрэг шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх шаардлагатай.

## **САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГООР ХИЛЭЭР НЭВТЭРЧ БҮЙ БЭЛЭН МӨНГӨНИЙ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГТ ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

72. ФАТФ-н 32 дугаар зөвлөмж нь улс орнуудыг гэмт хэргийн улмаас олсон орлогыг шилжүүлэх мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гол аргын нэг болох хил дамнуулан валют болон төлбөрийн хэрэгсэл тээвэрлэх үйдлийг илрүүлэх, таслан зогсоход чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг

уриалдаг.<sup>15</sup> Цугларсан энэ төрлийн мэдээлэл нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд хэрэг болж болно. Улмаар ийм төрлийн мэдээлэл нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зорилгоор хууль сахиулах байгууллагаар үнэлэгдсэн, шалгагдсан эсхүл дүн шинжилгээ хийгдсэн байвал зохино. Ийм төрлийн дүн шинжилгээ хийснээр тогтмол хилээр нэвтэрдэг зорчигсод, тэдгээрийн хоорондын холбоог олж илрүүлэх, түүнчлэн бусад нотлох баримт, хэрэгт ач холбогдолтой бусад нөхцөл байдлыг нээж олоход хүргэдэг. ФАТФ-н 32 дугаар зөвлөмж нь гаалийн худал мэдүүлэг, мэдээлэл өгсөн этгээд болон улсын хилээр биет хэлбэрээр МУТС-тэй холбоотой бэлэн валют эсхүл төлбөрийн хэрэгсэл тээвэрлэж яваа этгээдэд гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн эрүүгийн, иргэний болон захиргааны шийтгэлийн арга хэмжээ авах шаардлагатай. Практикт улс орнууд ийм төрлийн үйлдэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хариуцлагад татах, холбогдох ял шийтгэл хүлээлгэх боломжтой байх ёстой.<sup>16</sup>

73. ФАТФ-н 32 дугаар зөвлөмж нь энэ төрлийн мэдээллийг СМА болон бусад дотоодын болон гадаадын түнш байгууллагатай хуваалцахыг уриалдаг. Ингэхдээ мэдээллийг зориулалтын дагуу ашиглах нөхцлийг бүрдүүлэхийн тулд аюулгүй байдал, хамгаалалтын хатуу дүрэм, журмыг мөрдүүлэх шаардлагатай. Ийм мэдээллийг хамгаалах хамгийн шалгарсан арга бол эрх зүйн хэм хэмжээний акт боловсруулах, харилцан ойлголцлын санамж бичиг мэтийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах нь зүйтэй. Хууль бус бэлэн мөнгө зөөвөрлөгчийг илрүүлэх ажилд ахиц гаргахын тулд СМА болон бусад дотоодын ба гадаадын түнш байгууллагын хооронд мэдээлэл солилцоо, эргэх холбоо шаардлагатай гэдгийг онцлон тэмдэглэх нь чухал. Дамжуулж буй мэдээлэл нь бүрэн бүтэн, СМА болон хууль сахиулах байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцсэн, шаардлагатай бүх мэдээллийг багтаасан байх нь чухал. Түүнчлэн, мэдээллийг цагт нь (болж өгвөл бодит цагт) солилцож байхыг сайн туршлага харуулдаг. ФАТФ-н 32 дугаар зөвлөмж нь улс

---

<sup>15</sup> ФАТФ (2015).

<sup>16</sup> Мөн тэнд.

орнуудыг хил дамнасан сэжигтэй бэлэн мөнгө тээвэрлэсэн тохиолдол, баримт фактын талаар СМА-д мэдээлэлдэг системийг бий болгож хэрэгжүүлэх эсхүл СМА-нд хил дамнасан сэжигтэй бэлэн мөнгө болон төлбөрийн хэрэгслийн талаарх мэдээлэлд нэвтрэх эрхтэй болгохыг шаарддаг. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллага мөрдөн шалгах ажиллагаа явуулах зорилгоор ийм төрлийн мэдээлэлд тогтмол нэвтрэх боломжтой байвал зохино.

74. ФАТФ-н “Бэлэн мөнгө хууль бусаар хил дамнуулан тээвэрлэх явдлыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх Тэргүүн Туршлага”<sup>17</sup> гэсэн баримт бичигт дурдсаны дагуу гаалийн хуурамч мэдүүлэг өгсөн эсхүл огт мэдүүлэг өгөөгүй шалтгааныг мөрдөн шалгах нь тагнуулын мэдээлэл цуглуулахад шаардлагатай хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг ил болгох эсхүл мөрдөн шалгах, яллах ажиллагаа, зорчигсдод хариуцлага хүлээлгэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой.<sup>18</sup> Энэ мэдээлэл нь идэвхтэй явагдаж буй санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд онцгой ач холбогдолтой байж болох бөгөөд хууль сахиулах байгууллагын ийм мэдээлэлд нэвтрэх эрх нь цаг үеэ олсон эсхүл үр нөлөөтэй байх ёстой. Үүнээс гадна, үнэн зөв гаалийн мэдүүлэг болон худал мэдүүлэгт дүн шинжилгээ хийсний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлсэн үйлдэл илэрч болох бөгөөд ийм мэдээлэл нь шинэ таамаглал дэвшүүлэх, нотлох баримт олох үүднээс санхүүгийн мөрдөн байцаагч нарын сонирхлыг татаж болно.

---

<sup>17</sup> Мөн тэнд.

<sup>18</sup> Мөн тэнд.

## VI. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ АРГА

75. Энэ хэсэг санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд ашиглаж болох төрөл бүрийн мөрдөн шалгах ажиллагааны аргын талаар тайлбарлана. Эдгээр мөрдөн шалгах ажиллагааны арга нь мөрдөн шалгах ажиллагааны иж бүрэн жагсаалтад тооцогдохгүй бөгөөд гагцхүү санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаатай тусгайлан холбоотой арга хэмжээг онцолсон болно. ФАТФ-н 31 дүгээр зөвлөмжид заасны дагуу улс орнууд мөрдөн шалгах ажиллагааны өргөн хүрээний аргыг ашиглах хэрэгтэй ба тэдгээрт халхавч ажиллагаа, харилцаа, холбооны сүлжээнд хяналт тавих, компьютерийн системд нэвтрэх, хяналттай хүргэлт зэрэг арга хэмжээ багтдаг. Улс орнууд ийм шаардлагыг өөрсдийн эрх зүйн тогтолцоонд нутагшуулж болно. Энэ зөвлөмж нь мөрдөн байцаагч нарын зүгээс санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд хамааралтай мэдээ, мэдээлэл олох янз бүрийн механизмтай байхыг хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал, зарим улс орон мэдээлэл гаргуулах тухай шүүгчийн захирамж, шүүхийн зарлан дуудах хуудас, прокурорын тогтоол, шүүхийн магистратын тушаал зэргийг ашигладаг. Ямар бичиг баримт, арга хэрэгсэл ашиглахаас үл хамааран санхүүгийн мөрдөн байцаагч нар шаардлагатай мэдээлэлд нэвтрэх эрхтэй байх, түүнчлэн шаардлагатай мэдээлэл гаргуулах эрх хэмжээгээ үр дүнтэй ашиглах чадамжтай байх нь чухал.

76. **Нууцаар ажиглах.** Нууцаар ажиглах нь хувь хүн, хуулийн этгээдийн талаарх ерөнхий болон тагнуулын шинжтэй мэдээ, мэдээллийг олох, түүнчлэн тэдгээрийн дадал, зуршил болон хань харилцааг илрүүлэхэд хэрэгтэй арга хэмжээ юм. Нууцаар ажиглах арга хэмжээ нь их хэмжээний бэлэн мөнгөний хөдөлгөөн, тээвэрлэлт хийгдэж буйтай холбоотой санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд нилээн үр дүнтэй байдгаас гадна мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх бүдүүвч схем, замын зураглал бүтээх, хөгжүүлэх, хэрэгжүүлэх үйл явцад хамтран оролцож буй хууль эрх зүйн болон санхүүгийн шинжээчийг илрүүлэхэд тустай байдаг. Сэжигтнийг нууцаар ажигласнаар санхүүгийн болон бусад бүртгэл, мэдээлэл

хадгалагдаж буй газрыг зааж өгөхийн зэрэгцээ хөрөнгө, мөнгөний байрлалыг олж илрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Түүнчлэн, нууцаар ажиглах арга хэмжээ нь өмнө нь авагдсан санхүүгийн мэдээллийг бататгах, бусад сэжигтэн, хамтран оролцогчийг олж тогтооход ач холбогдолтой.

**77. Хог хаягдлыг судлах** (нотлох баримт, эд мөрийн баримт олох зорилгоор сэжигтний хаясан хог хаягдлыг судлах) нь хөрөнгө, мөнгө хадгалагдаж буй газрыг олж тогтооход шаардлагатай мэдээллээр хангах үр дүнтэй арга байж болохын зэрэгцээ албадлагын шинжтэй хатуу арга хэмжээ авах үндэслэлийг бий болгоход нөлөөлөх, түүнчлэн энэ арга хэмжээний үр дүн нь шүүхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэж болно. Сэжигтэн санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд үнэ цэнэтэй санхүүгийн тайлан, бүртгэл, захидал, харилцаа зэрэг эд мөрийн баримтаасаа аль болох ангижран салахыг эрмэлздэг.

**78. Нотлох баримт цуглуулахын тулд албадлагын шинжтэй ажиллагаа явуулах.** Энэ аргыг буюу үзлэг, нэгжлэг хийхийг гэмт хэргийн нотлох баримтыг өөр аргаар цуглуулах боломжгүй болсон тохиолдолд ашиглавал зохистой. Нотлох баримт олж авах энэ эрх хэмжээг оновчтой цаг үед хэрэгжүүлбэл сэжигтнүүдийн зүгээс тайлан, бүртгэлээсээ ангижран салах, нотлох баримтаа устгах магадлалыг бууруулдаг. Аливаа тайлан, бүртгэл, бичиг баримтыг хураахаас гадна сэжигтний компьютерийн систем болон бусад цахим мэдээллийг хураан авч шалгах шаардлагатай. Эдгээр эрх хэмжээг хэрэгжүүлэхдээ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журам, зааврыг чандлан мөрдөж хууль ёсны дагуу гүйцэтгэх хэрэгтэй. Түүнчлэн, нотлох баримтын нэгдмэл байдлыг хамгаалахын тулд мөрдөн байцаагч нар нотлох баримттай харьцах журмыг чандлах баримталж нотлох баримт цуглуулж эхлэхээс шүүхэд танилцуулах хүртэлх бүхий л үе шатыг харуулсан хөтлөх хэргийн жагсаалт бүрдүүлнэ. Хэрэв ийм төрлийн нотлох баримттай харьцах журам, зааваргүй улс орнууд нотлох баримттай зүй зохистой харьцаж ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд ийм харилцааг зохицуулсан

дотоод заавар, журам боловсруулах хэрэгтэй. Ийм төрлийн заавар, журмыг мөрдөж ажиллах нь нотлох баримтын бүрэн байдлыг шүүхийн шатанд хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хамгаалдаг. Санхүүгийн мөрдөн байцаагч нар мөрдөн шалгах ажиллагааны явцад компьютер эсхүл бусад цахим мэдээллийн хэрэгсэлтэй гар бие оролцон ажиллах тохиолдолд тэдгээрт агуулагдаж буй нотлох баримтын үнэ цэнийг харгалзан үзэх шаардлагатай. Ийм нөхцөл байдал үүссэн үед сургаж бэлтгэгдсэн шүүхийн шинжилгээний компьютерийн мэргэжилтэн эсхүл техникийн шинжээчтэй зөвлөлдөх нь зохимжтой. Сургаж бэлтгэгдээгүй мөрдөн байцаагчийн зүгээс зориулалтын тоног төхөөрөмжгүйгээр цахим мэдээлэлд нэвтрэх, тээвэрлэх, шилжүүлэх, цахим нотлох баримтыг хадгалах оролдлого хийгдэх тохиолдолд үнэ цэнэтэй нотлох баримтыг санамсаргүй байдлаар гэмтээх эсхүл бүр мөсөн устгахад хүргэж болно. Бүх тохиолдолд, цахим нотлох баримтын эх хувийг нотлох баримт хадгалахад зориулагдсан хайрцаг, саванд хадгалахын зэрэгцээ нэгэн зэрэг үйл явдлын хураангуйг тоймлон бичгээр үйлдэж гаргах хэрэгтэй. Ийм нотлох баримтын дүн шинжилгээг компьютерийн шүүх шинжилгээний мэргэжилтнийг оролцуулан явуулах хэрэгтэй.

**79. Байцаалт.<sup>19</sup>** Мөрдөн байцаагч нар санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд нотлох баримт цуглуулахын тулд тайлбар авах, биечилсэн ярилцлага хийх, байцаалт авах аргыг ашиглана. Мөрдөн байцаагч нар эхний удаад сэжигтэн, гэрчүүдийн сайн дурын мэдүүлгийг авах оролдлого хийх хэрэгтэй. Харин, хэрэв сэжигтэн эсхүл гэрч сайн дураар ярилцлага хийж тавьсан асуултанд хариулахааргүй бол тэдгээрийн мэдүүлгийг улс орны хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм, журмын дагуу шаардах, шахалт, нөлөөлөл үзүүлэх, байцаалтын ов мэх ашиглан авч болно. Ийм төрлийн байцаалтыг сэжигтэн эсхүл гэрчийн зүгээс хамтран ажиллах санал тавьсны үр дүнд мөрдөн шалгах ажиллагаанд үзүүлэх боломжит сөрөг нөлөөллийг нарийн тооцолгүйгээр эхлүүлэхгүй байвал

<sup>19</sup> АНУ-н Дотоод Аюулгүй Байдлын Яам.



зохино. Мөрдөн шалгах ажиллагааны явц байдлын талаарх дэлгэрэнгүй тайланг явуулсан байцаалтын үр дүнтэй нэгтгэх шаардлагатай. Мөрдөн байцаагч нар мэдүүлэг, тайлбарыг нэмэлт баримтаар батлахад шаардлагатай нотлох баримтыг хууль ёсны бусад бүх аргаар олох боломжийг эрэлхийлэх хэрэгтэй. Байцаалтын үр дүнд хөтөлсөн тэмдэглэл нь эрүүгийн эсхүл иргэний шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны үед мөрдөн байцаагчийн эсхүл гэрчийн дүрсэлсэн үйл явдлыг сэргээхэд онцгой үнэ цэнэтэй байдаг.

**80. Хяналттай хүргэлт.** Энэ нь хууль сахиулах байгууллагын ажилтны зааварчилгаа эсхүл нууц ажиглалт дор улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа, бүтээгдэхүүн, валют, төлбөрийн хэрэгслийг сэжиглэгдэж буй этгээдэд тээвэрлэн хүргэхэд чиглэгдсэн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнтэй арга юм. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа, бүтээгдэхүүн, валют эсхүл төлбөрийн хэрэгслийг хилийн боомтоор орж, гарах үед илрүүлэн хураах эсхүл өөр халхавчилсан ажиллагаа явуулах мэтийн мөрдөн шалгах ажиллагааны арга ашиглан хураан авч болдог. Хяналттай хүргэлтийг дараах зорилгоор явуулна:

- Сэжигтэнг таньж олох, баривчлах, ял шийтгэх;
- Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа, бүтээгдэхүүн, валют эсхүл төлбөрийн хэрэгслийг хууль бусаар нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулдаг гэмт бүлэг, бүлэглэл, байгууллагын гэмт үйл ажиллагааг таслан зогсоох, задлан бутаргах;
- Мөрдөн шалгах ажиллагааны хүрээг өргөжүүлэх, нэмэлт сэжигтэн эсхүл онц аюултай гэмт этгээдийг олж илрүүлэх, нэмэлт нотлох баримт цуглуулах;
- Сэжигтэй этгээдүүд мэдсээр байж улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа, бүтээгдэхүүн, валют эзэмшиж байсныг нотлох;
- Сэжигтэн этгээдийн хөрөнгийг хураах, битүүмжлэх

зорилгоор хөрөнгийг олж илрүүлэх.

81. Хяналттай хүргэлт нь мөрдөн шалгах ажиллагааны үр дүнтэй арга хэдий ч энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх явцад зохих ёсоор анхаарч шийдвэрлэвэл зохих ноцтой эрсдлүүд байдгийг анхаарах шаардлагатай. Тухайлбал, хяналттай хүргэлтийн явцад нотлох баримт үрэгдэх эрсдэлтэй. Улс орнууд энэ төрлийн мөрдөн шалгах ажиллагааны аргыг ашиглахын тулд эрх бүхий байгууллагууд нь зохих түвшинд бэлтгэгдсэн эсэх, ийм арга хэмжээг хэрэгжүүлэх холбогдох журам, заавартай эсэх, тэдгээрийг зохих ёсоор мөрдөж, удирдлагын түвшинд хэрэгжилтэнд нь хяналт тавьдаг эсэхийг анхаарч харгалзах шаардлагатай.

82. **Харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих.** Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд цахим хяналтын арга болох утсан харилцааг хянах, нууцаар сонсох, цахим шууданг олзлох, байршил тогтоох төхөөрөмж ашиглах зэрэг цахим хяналтын арга нэлээд үр дүнтэй байдаг. Ийм арга хэмжээ нь хамтран оролцогчдыг тодорхойлох, гэмт бүлэглэл, байгууллагын үйл ажиллагааны талаар төсөөлөлтэй болгох, мөрдөн шалгах өөр ажиллагаа явуулах зорилгоор ашиглагдаж болох мэдээ, мэдээлэл, нотлох баримтыг бодит цаг хугацаанд нь хүлээн авахад тусалдаг бөгөөд, хөрөнгө, мөнгө, санхүүгийн тайлан бүртгэл болон бусад ач холбогдол бүхий мэдээлэл хадгалагдаж буй байршил руу хөтлөн авчирдаг.

83. Улс орнууд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зорилгоор харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих арга хэмжээг хүчин төгөлдөр үйлчилж буй дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчим, дүрэм, журмын дагуу зохих ёсоор явуулах талаар эрх бүхий байгууллагад сургалт явуулах үүрэгтэй. Улс орнууд мөрдөн шалгах ажиллагаанд ач холбогдолтой зорилтыг шийдвэрлэхэд чиглэгдсэн ийм арга хэмжээ явуулах нөөц бололцоог зохих ёсоор бүрдүүлсэн байна. Харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих арга хэмжээ нь хувь хүний алба, амины амьдрал, хувийн нууцад хөндлөнгөөс халддаг, их хэмжээний нөөц хөрөнгө шаарддаг,

албадлагын шинжтэй гэдгийг харгалзан улс орнууд энэ арга хэмжээг хуулийн дагуу, үр дүнтэй, зохистой ашиглах механизм бүрдүүлэх шаардлагатай.

**84. Халхавчилсан арга хэмжээ.** Энэхүү мөрдөн шалгах ажиллагааны арга нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахад үр дүнтэй хэдий ч мөн чанарын хувьд өөрийн гэсэн онцлог эрсдэлтэй. Халхавчилсан арга хэмжээ нь мөрдөн байцаагч нарын зүгээс өөр ямар ч аргаар олох боломжгүй чухал нотлох баримтыг илрүүлэх боломжийг ихэвчлэн олгодог. Халхавчилсан арга хэмжээ гэдэгт хууль сахиулах эрх бүхий байгууллагын ажилтан, гүйцэтгэх ажилтан хууль сахиулах байгууллагын тодорхой заавар, чиглэлийн дагуу нотлох баримт, мэдээлэл цуглуулахаар зохиомол аж ахуйн нэгж байгуулах, итгэл үнэмшилтэй дүрд хувирах үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. Халхавчилсан арга хэмжээг зохих ёсоор явуулахын тулд нилээд их хэмжээний хүч, хэрэгсэл, хөрөнгө, эрчимжүүлсэн өргөн хүрээний сургалт, бэлтгэл ажил шаарддаг. Ийм арга хэмжээ нь их хэмжээний хүч, хэрэгсэл, хөрөнгө зарцуулдаг, төрөл бүрийн онцгой бөгөөд төрөлжсөн ур чадвар эзэмшиж, туршлага хуримтлуулахыг шаарддаг. Мөн чанарын хувьд эрсдэлтэй гэдэг утгаараа энэ төрлийн мөрдөн шалгах ажиллагааны аргыг гарцаагүй нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлдэг. Ер нь уламжлалт мөрдөн шалгах ажиллагааны арга үр дүнгүй байгаа тохиолдолд халхавчилсан арга хэмжээг сонгож явуулдаг. Хууль сахиулах байгууллагын халхавчилсан арга хэмжээний үед явуулж буй үйл ажиллагаа нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн тулгуур зарчим, үзэл баримтлал, дүрэм, журамд нийцсэн байх ёстой бөгөөд халхавч дор үйл ажиллагаа явуулж буй гүйцэтгэх ажилтан ийм арга хэмжээнд татагдан оролцохоосоо өмнө өндөр түвшинд бэлтгэгдсэн байх шаардлагатай.

**85.** Мөрдөн шалгах ажиллагаанд халхавчилсан арга хэмжээ ашиглах асуудлыг авч үзэх тохиолдолд харгалзан үзвэл зохих төрөл бүрийн хүчин зүйлс бий. Мөрдөн байцаагч нар мэдээлэгчийн сэдэл, найдвартай байдлыг тодруулах (шаардлагатай тохиолдолд), хүчин төгөлдөр үйлчилж буй

хууль тогтоомжийн болон хэм хэмжээний актуудыг судлах, ирээдүйд хэрэгжүүлэх арга хэмжээнд татан оролцуулах этгээд дээр урьдчилсан мөрдөн шалгах ажиллагаа явуулж халхавчилсан арга хэмжээ нь хүссэн үр дүнд хүргэх эсэхийг эргэцүүлэн бодож ойлгох шаардлагатай. Мөрдөн байцаагч нар халхавчилсан арга хэмжээ явуулах хэрэгцээ, шаардлагад тогтмол дахин дахин үнэлгээ хийж хэрэв шаардлагатай тохиолдолд арга хэмжээг зогсооход бэлэн байх хэрэгтэй. Түүнчлэн, арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд оролцох хүнийг сонгох, дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүнд ажиллах ажилтныг сонгох, ашиглах тоног төхөөрөмжийн жагсаалт гаргаж бэлэн байдлыг хангах, төлөвлөгөө боловсруулж төсөв зохиох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүч, хэрэгсэл, нөөц, боломжийг тодорхойлох хэрэгтэй. Мөрдөн байцаагч нар түүнчлэн, халхавчилсан арга хэмжээг шаардлагатай тохиолдолд зогсоох шалгуурыг тодорхойлох, улс орны хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний акт, дүрэм, журмын дагуу прокурорын зөвшөөрөл болон бусад зайлшгүй шаардлагатай зөвшөөрлийг авсан байх шаардлагатай.

86. Мөрдөн шалгах ажиллагааны энэ арга нь мөн чанарын хувьд эрсдэлтэй гэдгийг харгалзан халхавчилсан арга хэмжээ явуулах саналыг эрх бүхий хууль сахиулах байгууллагын эрх бүхий албан тушаалтан судалж зөвшөөрөл олгодог байх ёстой. Эдгээр албан тушаалтан халхавчилсан арга хэмжээтэй холбоотой бүх нарийн чимхлүүр асуудлыг мэдэж байх ёстой. Тэр ч байтугай, халхавчилсан арга хэмжээ явуулах саналд уламжлалт мөрдөн шалгах ажиллагааны аргыг ашигласан боловч хүлээж байсан үр дүнгээ өгөөгүй, харин халхавчилсан арга хэмжээ нь сэжигтэй гэмт үйл ажиллагааны талаар нотлох баримт цуглуулах боломжийг олгож болзошгүй цорын ганц арга хэмжээ гэдгийг тодорхой тусгаж өгөх шаардлагатай. Гагцхүү өндөр түвшинд бэлтгэгдсэн нууц ажилтан халхавчилсан арга хэмжээнд оролцох ёстой.<sup>20</sup>

<sup>20</sup> АНУ-н Дотоод Аюулгүй Байдлын Яам, Халхавчилсан арга хэмжээний талаар нэмэлт мэдээллийг олж үзэх.

87. **Орлого, зарлаг шалгах арга.** Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг нь санхүүгийн үр ашиг эсхүл суурь гэмт хэргээс олсон орлогыг тодорхойлох явдал байдаг. Хууль бусаар олсон орлогын хэмжээг тогтоох нь гэмт хэргийн сэдлийг бататгаж суурь гэмт хэрэг үйлдсэнийг шууд бусаар гэрчилдэг. Ийм учраас, санхүүгийн мөрдөн байцаагч нар олсон орлого, зарлагыг шалган нягтлах төрөл бүрийн арга, техникт мэргэшин гаршсан байхын зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагааны тодорхой баримт, хэргийн нөхцөл байдалд үндэслэн ямар аргыг ямар тохиолдолд хэрэглэхийг тодорхойлох чадвартай байх нь туйлын чухал байдаг.

88. Энэхүү зөвлөмжөөр олсон орлогыг шалгах хоёр үндсэн нотлох баримтын аргыг авч үзэн тайлбарлана. Эдгээрт шууд нотлох баримт ашиглах (шууд нотлох баримтын арга) эсхүл дараах шууд бус гурван төрлийн нотолгооны арга ашигладаг. Үүнд: 1) цэвэр өртөг ба зарлага; 2) орлого олох эх үүсвэр болон түүний зарцуулалт; 3) банкны хадгаламж. Эдгээр аргыг зөвлөмжийн хавсралт хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлах болно.

89. Санхүүгийн мөрдөн байцаагч нар санхүүгийн дүн шинжилгээ хийхдээ шууд бус нотолгооны арга ашигладаг. Шууд бус нотолгооны бүх аргыг ашиглах тохиолдолд хэргийг нотлох явцад тодорхой хүндрэл, саад, тотгор үүсч болзошгүйг санхүүгийн мөрдөн байцаагч нар мэддэг байх шаардлагатай. Энэхүү хүндрэл, саад, тотгорыг дор дурдсан мөрдөн шалгах ажиллагааг зохих ёсоор явуулах замаар даван туулах боломжтой:

- Бүх орлогын эх үүсвэр болох өв залгамжлал, зээл, данснуудын хоорондын шилжүүлгийг орхигдуулалгүй харгалзан үзэх. Татвараас зайлсхийх ноцтой хэрэг эсхүл бусад суурь гэмт хэргийн орлогын хууль бус эх үүсвэрийг мөрдөн шалгах үед мэдүүлээгүй орлогыг яв цав, нарийн тооцолохын тулд тухайн хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжийн ердийн үед олдог, хуримтлуулдаг орлогын эх үүсвэртэй холбогдохгүй байгаа бүх

орлогыг тодорхойлох шаардлагатай;

- Сэжигтний зүгээс өөрсдийгөө хамгаалах зорилгоор гаргаж тавьж буй аливаа эсэргүүцлийг тооцож шийдвэрлэж байх. Шууд бус нотолгооны арга нь илэрхий нөхцөл байдалд суурилсан (circumstantial evidence) нотлох баримтанд суурилдаг. Сэжигтний танилцуулж буй үндэслэл бүхий өөрийгөө хамгаалах зорилготой аливаа эсэргүүцлийг үндэслэлтэй, бодит байдалд нийцэж буй эсэхийг тодорхойлон нягтлах шалгах шаардлагатай;
- Татвараас зайлсхийх эсхүл бусад суурь гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцад мэдүүлэгт тусгаагүй боломжит орлогын эх үүсвэрийг тайлбарлах боломжгүй орлогын эх үүсвэр гэж ангилан тодорхойлох;
- Мөрдөн байцаагч нь бэлэн мөнгө болгон хувиргаж болох бүх чекийг олж илрүүлэх, тэр тусмаа банкны дансыг нягтлах нотолгооны арга ашиглаж буй тохиолдолд өөр ямар нэгэн бүртгэгдээгүй чек байгаа эсэхийг тодорхойлох. Учир нь бэлэн болгон хувиргах бололцоотой чек болон бүртгэгдээгүй чекийг банкны дансанд байршуулсан, хадгалсан эсхүл зарцуулсан бэлэн мөнгөний орлогын эх үүсвэр гэж тооцох шаардлагатай. Энэ тохиолдолд мөрдөн байцаагчийн уг үндэслэлийг няцаах нотлох баримт илрэх эсэхийг тооцоолох шаардлагатай.

## VII. СУРГАЛТ

90. Сургалтын болон боловсролын хөтөлбөрийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад зориулж стандартчлах шаардлагатай. Анхан шатны мэдлэг олгох сургалтыг шинэ ажилтанд зайлшгүй явуулах шаардлагатай бол мэргэшүүлэх сургалтыг сонгогдон шалгарсан ажилтанд ажил үүргээ хүлээн авах үед болон мөрдөн байцаагчийн ажлыг гүйцэтгэх бүх хугацааны туршид үргэлжлүүлэн явуулах шаардлагатай. Гэвч ийм мэргэшүүлэх сургалт нь санхүүгийн мөрдөн байцаагч болон санхүүгийн дүн шинжээчдийн гүйцэтгэх үүрэг, даалгавараас шалтгаалан ялгаатай байх ёстой. Ийм онцгой мэргэжил сонгосон ажилтан ажил мэргэжлийн хувьд өсөн дэвжих, өрсөлдөхүйц цалин, хангамж, нэмэгдлээр хангагдах боломжтой байх ёстой. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах суурь мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх сургалт хууль сахиулах байгууллагын шинэ ажилтан болон бусад туршлагатай мөрдөн байцаагчийг бэлтгэх хөтөлбөрт багтсан байвал зохино.

91. Сургалтын хөтөлбөр нь ажлын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх ёстой. Зохих шалгуурын дагуу шалгаруулан авсан ажилтныг дараах гурван үндсэн хичээлийн сэдвээр сургах шаардлагатай. Үүнд: санхүүгийн тагнуулын үйл ажиллагаа; нотлох баримт цуглуулах; хөрөнгө олж илрүүлэх/битүүмжлэх. Дараагийн сургалтыг мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа; санхүүгийн тагнуулын өргөтгөсөн мөрдөн шалгах ажиллагаа; яллах тогтоолтой эсхүл яллах тогтоолгүй хөрөнгө хураах ажиллагаа. Боломжтой бол ийм сургалтыг хууль сахиулах байгууллагын чиглэлийн ахлах ажилтан, удирдах ажилтан болон мэргэшсэн прокурортой хамтатган зохион явуулбал зохимжтой. Түүнээс гадна, шүүгчийг холбогдох хууль тогтоомжийг зөв хэрэглэх, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой хэргийг зохих ёсоор хянан шийдвэрлэх чиглэлээр сургах шаардлагатай.

92. Сургалт нь зөвхөн хууль сахиулах байгууллагыг хамрах нь учир дутагдалтай бөгөөд сэжигтэй гүйлгээний тайлан ирүүлэх

үүрэгтэй салбарыханд болон эрсдэл учруулж болзошгүй бусад салбарын оролцогч нарт зориулан зохион байгуулдаг байх шаардлагатай. ФАТФ болон ФАТФ-тай ижил төстэй бүс нутгийн байгууллага мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой төрөл бүрийн арга, техникийг дүрсэлсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн арга техник, хэв маяг, чиг хандлагын тайланг тогтмол боловсруулж олон нийтийн хүртээл болгодог. Мөн ийм төрлийн тайланг ашиглан санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой сургалтыг явуулбал үр дүнтэй байж болно.

93. Тэргүүн туршлага солилцох, өөр эрх зүйн систем, үйл ажиллагааны журамтай холбоотой ялгаатай болон төсөөтэй талуудыг харьцуулан судлах, хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд хэд хэдэн улс орны төлөөлөл багтсан сургалт явуулбал үр өгөөжтэй байдаг. Түүнээс гадна ажилтнууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх шинэ арга хэлбэр, чиг хандлага гарч ирэх тохиолдолд бэлэн байдалтай байх ёстой. Улс орнууд санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийг дагнан шалгадаг мөрдөн байцаагч нарыг гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг түншүүд нь оролцдог бүс нутгийн болон олон улсын сургалтын семинарт тогтмол оролцуулах нөхцлийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлдэг байх ёстой.

94. Тайлан, мэдээ боловсруулах нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны хамгийн чухал хэсэг бөгөөд санхүүгийн мөрдөн байцаагч болон мэдээллийн дүн шинжээч нарт зориулсан тайлан, мэдээ бичих, боловсруулах, дадал олгох нь сургалтын хөтөлбөрт зайлшгүй багтсан байх ёстой. Мөрдөн шалгах ажиллагааны явцад аливаа ойлголт, ухагдахуун, ажлын үр дүн, оюун дүгнэлтийг ойлгомжтой, цэгцтэй, агууламжтай танилцуулж хүргэх чадвар нь нарийн төвөгтэй санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны амжилтын гол түлхүүр юм. Улс орнууд тайлан мэдээ бичиж боловсруулах үр чадвар суулгах эрх бүхий байгууллагын ажилтанд зориулсан үр дүнтэй сургалтад шаардлагатай нөөц, хөрөнгийг гаргадаг байх хэрэгтэй. Мөрдөн шалгах ажиллагаа нь урт, сунжирсан, нарийн төвөгтэй, улс дамнасан шинжтэй байдаг тул санхүүгийн мөрдөн шалгах



ажиллагаанд тайлан, мэдээ бичиж боловсруулах нь хамгийн ач холбогдолтой. Нямбай, алдаа мадаггүй, цаг үеэ олсон, агуулгын хувьд товч тодорхой тайлан мэдээ нь шүүхээс шаарддаг нотлох баримтын шалгуурыг хангах зорилготой ерөнхий танилцуулгыг бичиж боловсруулах, түүнчлэн, нотлох баримт ирүүлэх тухай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт боловсруулахад тус дөхөмтэй байдаг. Практикийн ажилтнууд мөрдөн шалгах ажиллагааны бүх үе шатанд болон ач холбогдолтой үйл явдлын дараа ажлын үр дүн, ололт, амжилтаа тухай бүр нь баримтжуулж байх нь туйлын чухал байдаг. Тайлан, мэдээг болж өгвөл үйл явдал болсон тухайн өдөр нь ойлгомжтой, товч тодорхой дүрсэлж бичиж боловсруулан, холбогдох бүх нэмэлт мэдээлэл, үйл явцыг тусгах хэрэгтэй. Тайлан мэдээг аль болох богино хугацаанд дээд шатны албан тушаалтны зүгээс хянаж батламжилдаг байх шаардлагатай.

95. Санхүүгийн мөрдөн байцаагч нарт зориулсан сургалтын загвар хөтөлбөр олон нийтэд нээлттэй байдаг.<sup>21</sup> Эдгээр сургалтын хөтөлбөр нь бүрэн биш хэдий ч өндөр ур чадвартай санхүүгийн мөрдөн байцаагч бэлтгэхэд шаардлагатай олон төрлийн ур чадварыг авч үздэг.

---

<sup>21</sup> Үндэсний Цагдаагийн Агентлагийн цахим хуудсан дээрх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, Golobinek R., (2006) удирдамжийг үзнэ үү.

## VIII. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

96. ФАТФ-н 40 дүгээр зөвлөмж нь “Улс орнууд өөрсдийн эрх бүхий байгууллагыг мөнгө угаах болон түүнтэй холбоотой суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой өргөн цар хүрээтэй олон улсын хамтын ажиллагааг түргэн шуурхай, бүтээлч, үр дүнтэй үзүүлэх чадвартай байх түвшний арга хэмжээ авах үүрэгтэй” гэж тодорхойлдог. Энэ зөвлөмж нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг амжилттай явуулахад олон улсын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь ихэнхдээ үндэсний хил хязгаараар хязгаарлагддаггүй учраас эрх бүхий байгууллага албан ёсны болон албан бус хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд өөрсдийн хүч, хэрэгслээ төвлөрүүлэх нь туйлын чухал бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны бүхий л үе шатанд хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй. Урьдчилсан байдлаар олон улсын түншийн харилцаа тогтоосноор гадаад улс орнуудын эрх зүйн систем, нэмэлт мэдээлэл гаргуулахад учирч болзошгүй хүндрэл, бэрхшээлийг ойлгох, цаашдын үйл ажиллагааны стратегийг тодорхойлох боломжийг олгодог. Ингэснээр гадаадын улс орнуудад гадаад хамтын ажиллагаанд өөрсдийн гүйцэтгэх үүргээ тодорхой болгох боломжийг олгодог.

97. Санхүүгийн мөрдөн байцаагч нарын ашигладаг олон улсын хамтын ажиллагааны тодорхой сувгууд байдаг. Үүнд:

- гадаад улс орны нутаг дэвсгэрт эсхүл өөрийн улс орны нутаг дэвсгэрт ажиллаж буй холбогч офицеруудаар дамжуулан харилцах;<sup>22</sup>
- Интерпол, Европол (Европын Холбооны Цагдаагийн байгууллага) болон бусад бүс нутгийн хууль

<sup>22</sup> Эдгээрт EUROJUST (Европын Холбооны бус улс орны зарим офицероос бүрдсэн Европын агентлаг) хэмээх олон улсын байгууллага эсхүл дэлхийн аль ч өнцөг булан бүрт (Европын Холбоонд тухайлбал, Эрүүгийн хэргийн Европын Шүүхийн Холбоо сүлжээ гэж байдаг) байрлаж болох Олон улсын шүүхийн эсхүл цагдаагийн нийгэмлэг, нэгтгэлүүд багтдаг.

сахиулах байгууллагын хамтын ажиллагааны сувгийг ашиглан үндэсний (эсхүл бүс нутгийн) цагдаагийн байгууллагын салбар, нэгжтэй мэдээлэл солилцох;

- Хилийн чанадад гадаад түншийн өргөн харилцаатай, Эгмонт (Олон улсын санхүүгийн тагнуулын албадын холбоо)-н хамгаалалттай цахим хуудсаар мэдээлэл цуглуулах боломжтой үндэсний Санхүүгийн тагнуулын албанд хандах;
- Гадаад улс орнуудад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт дамжуулах эрх бүхий төв байгууллагаар дамжуулан харилцах.

98. Мөрдөн байцаагч, прокурорын байгууллага нь шүүхэд хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд хүлээн зөвшөөрөгдөх хууль ёсны нотлох баримт олж авахын тулд харилцан эрх тэгш байх зарчимд үндэслэсэн олон улсын гэрээ, хэлэлцээр, харилцан ойлголцлын санамж бичиг, хоёр талт болон олон талт гэрээ ашиглах ёстой. Ямар улс орон хэргийг ямар үе шатанд мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх үүрэгтэй болж байгаа шийдвэр гармагц шүүхийн таслан шийдвэрлэх ажиллагаанд ашиглагдах боломжтой, байцаан шийтгэх ажиллагааны журам зөрчөөгүй бүхий л шаардлагатай нотлох баримтыг тухайн улс оронд олж авах боломжтой механизмыг урьдчилан тохирч бүрдүүлэх шаардлагатай.

99. Гадаадын түнш байгууллагатай албан бус харилцаа бий болгох нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны амжилтад чухал ач холбогдолтой. Гадаадын түнштэй утсан харилцаа, цахим шуудан, видео-хурал, биечилсэн нүүр тулсан уулзалт хийх нь эцсийн дүндээ хэргийг амжилттай шалган шийдвэрлэхэд эерэгээр нөлөөлдөг. Идэвхтэй харилцаа холбоо нь хэрэг шалган шийдвэрлэх бүх үе шатанд чухал ач холбогдолтой. Үүнд: мэдээ, мэдээлэл цуглуулах, алсын хараатай шийдвэр гаргах, эрх зүйн харилцан туслалцааны гэрээтэй холбоотой гадаад улс орнуудын тавьж буй шаардлагыг ойлгох, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийн

төсөл боловсруулах, явуулсан хүсэлтийн араас хөөцөлдөх. Идэвхтэй харилцаа холбоо нь мэдээлэл гаргуулах хугацааг богиносгож үйл явцыг түргэтгэдэг, ялангуяа хууль зүйн нэр томьёоны ялгаатай байдлаас шалтгаалсан үл ойлголцол үүссэн тохиолдолд.

100. Зарим нэг чухал мэдээллийг илүү хурдан, хүнд сурталгүй, албан ёсны, нүсэр бичиг цаас аль болох бага солилцож түншийн харилцаатай хууль сахиулах байгууллага, санхүүгийн тагнуулын албадтай шууд харилцах замаар эсхүл орон нутаг болон бүс нутагт томилогдсон холбогч офицер эсхүл хууль сахиулах байгууллагын атташегаар дамжуулан авч болно (агентлагын түвшинд туслалцаа үзүүлэх). Ийм харилцан хамтын ажиллагаа нь нотлох баримт, хөрөнгийг аль болох хурдан хугацаанд олж илрүүлэх, шаардлагатай туслалцаа үзүүлэх, тэр ч байтугай, хамгийн чухал нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт явуулах зохих үндэслэлийг бэлтгэх үйл явцыг хөнгөвчилдөг (засгийн газрын түвшинд туслалцаа үзүүлэх). Байгууллага хоорондын ийм хамтын ажиллагаа нь гадаад улс орнуудын эрх зүйн тогтолцоо, хүчин төгөлдөр журам, зааврыг судлах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, эрүүгийн хэрэг үүсгэн шалгах, гэмт хэргийн улмаас олсон орлоготой холбоотой арга хэмжээ авч хэрэгжүүлэх бололцоог үнэлэх боломж олгодог.

101. Олон улсын хамтын ажиллагааны арга хэрэгслийг үр ашигтай, үр дүнтэй өргөн хүрээнд ашиглахын тулд санхүүгийн мөрдөн байцаагч нар гадаадын түнштэйгээ ажлын арга барил, хамтарсан төлөвлөгөөгөө хэлэлцэж байх нь чухал байдаг. Түншийн харилцаатай гадаадын байгууллагатай хийх ажил хэрэгч, уулзалт, хэлэлцээрийн зүйл, агуулга нь хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжийн талаар эсхүл гадаадын эрх бүхий байгууллагаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломж, нөхцлийг хангахын тулд холбогдох мэдээллийг шилжүүлэх зэрэг асуудал хамаарах ёстой. Хэрэв санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь бойжилтын үе шатандаа байгаатай холбогдуулан мөрдөн байцаагч нар мөрдөн шалгах ажиллагааны бүрэн бүтэн байдал алдагдахаас

санаа зовниж байгаа бол гадаадын түнштэйгээ холбогдож ер нь үүсэж буй асуудалтай холбогдуулан цаашид мөрдөн шалгах ажиллагааны ирээдүйн төлөв байдал хэрхэн өрнөх талаар хэлэлцэн зөвлөлдөж болно. Ийм хэлбэрийн зөвлөлдөх уулзалт нь мөрдөн шалгах ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг задруулалгүй мөрдөн шалгах ажиллагааны шалгуур, хүрээ, хязгаарыг бүх оролцогч талд илүү ойлгуулах боломжийг олгодог. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг шаардлагатай бол мөрдөн шалгах ажиллагааны эцсийн үе шатанд ил болгон хэлэлцэх боломжтой.

102. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг үндэстэн дамнасан шинж чанарыг харгалзан бүх улс орон мөнгө угаах, түүнтэй холбогдсон суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг өөрийн улс орны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн эсхүл хилийн чанадад үйлдэгдсэн эсэхээс үл хамааран мөрдөн шалгах, эрүүгийн хэрэг үүсгэн шалгах, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гаргах чадамжтай байх ёстой. Хэрэв суурь гэмт хэрэг нь өөр улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бол мөнгө угаах хэргээр эрүүгийн хариуцлагад татахын тулд хилийн чанадад үйлдэгдсэн суурь гэмт хэргийн талаарх мэдээлэл шаардлагатай болдог. Тийм учраас ийм мэдээллийг олж авах зохих нөхцлийг бүрдүүлсэн байх ёстой.

103. ФАТФ-н хөрөнгө хураах тэргүүн туршлага<sup>23</sup> хэмээх зөвлөмжид улс орнуудын хууль, эрх зүйн орчинг бэхжүүлэхэд туслах, хөрөнгө илрүүлэх болон санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах тэргүүн туршлагыг авч үздэг. Эдгээр тэргүүн туршлага нь мэдээ, мэдээллийг албан бусаар солилцох боломжийг нээж өгсөн зохих эрх зүйн зохицуулалт, журамтай байх, гадаад харилцан хамтын ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор зохих бүс нутгийн болон олон улсын байгууллагыг ашиглах, талууд санаачлагаараа мэдээллийг үл задруулах аюулгүй байдлын зохих журмын дагуу мэдээлэл солилцох, болон илрүүлсэн нуугдмал хөрөнгийг хуваах гэрээ, хэлэлцээр байгуулах зэрэг асуудлыг хөнддөг.

---

<sup>23</sup> ФАТФ-н (2010).

## ХАВСРАЛТ

### НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

#### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭГДВЭЛ ЗОХИХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

- Хуулийн этгээдийн нэр (регистрийн дугаар, бүртгэлийн дугаар);
- Албан ёсоор байгуулагдсан, бүртгэгдсэн огноо;
- Хуулийн этгээдийн төрөл (тухайлбал, ХХК, ХК, ХН);
- Хуулийн этгээдийн эрх зүйн байдал (жишээ нь, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа, идэвхгүй байгаа, татан буугдсан - хэрвээ татан буугдсан бол хуулийн этгээдийн татан буугдсан огноо болон өнгөрсөн хугацаанд бүртгэгдсэн бүх мэдээлэл);
- Хуулийн этгээдийн үндсэн албан байр эсхүл үйл ажиллагааны байрлал;
- Хуулийн этгээдийн бүртгэлтэй албан байр (гол албан байрнаас өөр бол) эсхүл бүртгэл хийсэн зуучлагчийн нэр болон хаяг;
- Хуулийн этгээдийн удирдлагын талаарх мэдээлэл, тухайлбал, захирал, гүйцэтгэх захирал, бусад албан тушаалтан, ажилтан (ерөнхийлөгч, нарийн бичиг);
  - —Хэрэв, хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, удирдлага нь хувь хүн бол түүний бүтэн нэр, хэрэв овог өөрчлөгдсөн бол өмнөх овог, оршин суугаа хаяг, иргэншил, төрсөн огноо;
  - —Хэрэв хуулийн этгээд үүсгэн байгуулагч, удирдлага нь компани бол хуулийн этгээдийн нэр, үндсэн албан байрны хаяг, бүртгэгдсэн оффисын хаяг, хэрэв боломжтой бол гадаадын хөрөнгө оруулалттай компаний хувьд анх

үүсгэн байгуулагдсан улсад бүртгэгдсэн оффисын хаяг.

- Өнгөрсөн хугацаанд хуулийн этгээдийг бүртгүүлэхээр ирүүлсэн мэдээлэл (тухайлбал, үүсгэн байгуулах бичиг баримт, жилийн тайлан, санхүүгийн тайлан, бүртгэл, бүртгэгдсэн оффисын байрны өөрчлөлт, бүртгэсэн зуучлагчийн өөрчлөлт гэх мэт);
- Жилийн тайлан - хуулийн этгээдийн бүртгэлийн системд бүртгэгдсэн хуулийн этгээдийн мэдээллийн үнэн зөв байдлыг зайлшгүй нягтлах шаардлагын дагуу хуулийн этгээдийн мэдээлэлд хамгийн сүүлд өөрчлөлт орсноос хойш ямар нэгэн өөрчлөлт ороогүй байсан ч жилийн тайлан ирүүлэх;
- Боломжтой бол хуулийн этгээдийг бүртгүүлэхээр өгсөн бичиг баримт, болон хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн цахим хуулбар (тухайлбал, үүсгэн байгуулах бичиг баримт, жилийн тайлан, санхүүгийн тайлан, бүртгэл, бүртгэгдсэн оффисын байрны өөрчлөлт, бүртгэсэн зуучлагчийн өөрчлөлт гэх мэт).

## ХАЛХАВЧИЛСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

### АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮНИЙ НӨӨЦ, ТЭДГЭЭРИЙН МЭРГЭЖЛИЙН БЭЛТГЭЛ

1. Палермогийн Конвенцийн 29 дүгээр зүйлийн (1) (G) нь улс орнуудад өөрийн хууль сахиулах байгууллагын ажилтан тэр дундаа прокурор, мөрдөн байцаагч нар, гаалийн ажилтанд зориулсан халхавчилсан арга хэмжээ зохиох талаар тусгайлсан сургалтын хөтөлбөр санаачлах, боловсруулах, боловсронгуй болгохыг уриалдаг. Халхавчилсан арга хэмжээнд оролцох ажилтны тоо, арга хэмжээний шинж чанар, цар хүрээнээс шалтгаалдаг.

### ЗОХИХ ТҮВШИНД ЯНЗ БҮРИЙН ДҮРД ХУВИРАН ТОГЛОХООР БЭЛТГЭГДСЭН НУУЦ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛТНЫГ ГОЛ ТӨЛӨВ ХАЛХАВЧИЛСАН АРГА ХЭМЖЭЭ БҮРТ ТАТАН ОРОЛЦУУЛДАГ.

2. Тухайлбал, багийн ахлагчийн үүрэг бол арга хэмжээнд бүхэлд нь ерөнхий хяналт тавих, бусад арга хэмжээнд оролцогчийн өдөр тутмын үйл ажиллагаа нь арга хэмжээний зорилгод чиглэгдэж байх бүх нөхцлийг хангахад оршино. *Тодорхой халхавч дор ажиллаж буй хууль сахиулах байгууллагын гүйцэтгэх ажилтан (cover agent)* нь халхавчилсан арга хэмжээ явагдах газар байрлаж, нууц гүйцэтгэх ажилтан (undercover agent)-тай холбоо барих, түүний нууцлал, аюулгүй байдлыг хангах үндсэн үүрэг хүлээнэ. Нууц гүйцэтгэх ажилтан (undercover agent) нь зохих түвшинд бэлтгэгдсэн байх бөгөөд түүнийг нэг байрлалаас нөгөө байрлалд халхавчилсан арга хэмжээ явагдах бүсэд шилжүүлэн байршуулна. Халхавчилсан арга хэмжээ явуулах тодорхой тохиолдолд өөр өөр нэр ашиглахын тулд нууц гүйцэтгэх ажилтан нь хэд хэдэн нэртэй байж болно. Техникийн ажилтан (*tech agent*) нь харах, сонсох ажиглалтын төхөөрөмж суурилуулах, ажиллуулах мэдлэг, ур чадвартай, бэлтгэгдсэн техникийн мэргэжилтэн байна. Техникийн ажилтан нь халхавчилсан арга хэмжээний байнгын гишүүн байх бөгөөд тогтмол зохиогддог арга хэмжээний явц



байдлын уулзалт, зөвлөгөөн, арга хэмжээний өмнөх болон дүнгийн уулзалтад оролцож байх ёстой. Гүйцэтгэх ажилтан (case agent) нь халхавчилсан арга хэмжээний өдөр тутмын бүх үйл явцыг удирдана. Тэрээр авагдсан бүх мэдээлэл, нотлох баримтыг цаг тухайд нь шалгах, дүн шинжилгээ хийх, үнэ, цэнийг тодорхойлох үүрэг хүлээнэ. Гүйцэтгэх ажилтан нь арга хэмжээний явц, дүнгийн тайлан, илтгэх хуудас бэлтгэх, нотлох баримтыг баримтжуулах, бичлэгүүдийг хуулбарлан хадгалах, түүнчлэн бүртгэл хөтлөхтэй холбоотой бусад үүрэг хүлээнэ.

### **НУУЦ МЭДЭЭЛЭГЧ (CONFIDENTIAL INFORMANTS)**

3. Халхавчилсан арга хэмжээ нь нууцаар хамтран ажилладаг хувь хүмүүсийн дэмжлэг туслалцаанд тулгуурлаж болно. Хувь хүний дэмжлэг нь арга хэмжээний амжилтад нилээд эерэгээр нөлөөлдөг. Мэдээллийн өргөн боломжтой нууцаар хамтран ажилладаг хувь хүн нь нууц гүйцэтгэх ажилтныг арга хэмжээний объекттой анхны харилцаа тогтоох, түүний итгэлийг олоход туслалцаа үзүүлж чаддаг. Хэдийгээр нууцаар хамтран ажиллаж буй мэдээлэгч нь мөрдөн шалгах ажиллагааны багийн гишүүн биш боловч зарим тохиолдолд халхавчилсан арга хэмжээ явуулж буй хууль сахиулах байгууллагын хяналтад байдаг итгэмжлэгдсэн этгээдэд тооцогддог. Мэдээлэгч нь халхавчилсан арга хэмжээ явуулахад ихэнх тохиолдолд голлох үүрийг гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч холбогдох хууль сахиулах байгууллагын ажилтан нууц мэдээлэгчийн аливаа халхавчилсан арга хэмжээний хүрээнд явуулж буй бүх үйл ажиллагаанд сайтар хяналт тавьдаг байх ёстой.

### **ХАЛХАВЧИЛСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНД ОЛСОН МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, БОЛОВСРУУЛАХ**

4. Халхавчилсан арга хэмжээний явцад цуглуулсан мэдээлэл, нотлох баримтыг нууц гүйцэтгэх ажилтны бэлтгэсэн ажлын тайлан, илтгэх хуудасны хүрээнд тодорхой халхавч дор ажиллаж буй хууль сахиулах байгууллагын гүйцэтгэх ажилтанд

дамжуулна. Энэхүү тайлан, илтгэх хуудсанд халхавчилсан арга хэмжээтэй холбоотой нууц гүйцэтгэх ажилтны үйл ажиллагааг нарийвчлан тусгадаг. Нууц гүйцэтгэх ажилтан нь үүрэг гүйцэтгэх хугацаандаа харилцаа тогтоосон бүх хүний нэрсийг тайлан, илтгэх хуудсандаа тусгахын зэрэгцээ өдөр тутамд болсон үйл явдлын тоймыг оруулах ёстой.

5. Нууц гүйцэтгэх ажилтан болон арга хэмжээний объектын хооронд цахимаар хийгдсэн ярианы бичлэг нэмэлт, мэдээ, мэдээлэл болон нотлох баримтын эх сурвалжид тооцогдож болно. Энэхүү ярианы бичлэгийн агуулга нь нууц гүйцэтгэх ажилтны өдөр тутмын үйл ажиллагааны тайлан, илтгэх хуудсанд тусгагдахгүй бөгөөд харин хэнтэй, хэдэн цагийн үед яриа хийгдсэн талаарх мэдээлэл тэмдэглэгдэх ёстой.

6. Мөрдөн шалгах ажиллагааны багийн гишүүд болон дэмжих бүрэлдэхүүний зүгээс мөн нууц ажиглалтын арга хэмжээ, улсын бүртгэлийн байгууллага, хууль сахиулах байгууллага дахь харилцаа холбоогоор дамжуулан лавлагаа авах, санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг мөрдөн шалгах ажиллагааны тусламжтай нэмэлт мэдээлэл болон нотлох баримт олж болно.

### **ХАЛХАВЧИЛСАН АРГА ХЭМЖЭЭГ ТОЙМЛОХ, ДҮГНЭХ**

7. Идэвхтэй явагдаж буй халхавчилсан арга хэмжээнд үе үе (90 хоногийн давтамжтай) хяналт тавьж арга хэмжээг тоймлох уулзалт, зөвлөгөөн хийж байх шаардлагатай. Ийм зөвлөгөөнд багийн ахлагч, гүйцэтгэх ажилтан, тодорхой халхавч дор ажиллаж буй гүйцэтгэх ажилтан оролцох бөгөөд хэрэв боломжтой бол нууц гүйцэтгэх ажилтныг байлцуулна. Энэхүү уулзалт нь арга хэмжээний явц байдлыг хэлэлцэж тавьсан зорилтдоо хүрч байгаа эсэхийг тодорхойлно. Түүнчлэн, зорилгодоо хүрэхэд шаардлагатай арга хэмжээний стратеги ба үйл ажиллагаанд гарсан аливаа өөрчлөлтийг хэлэлцэнэ. Ийм төрлийн зөвлөгөөний явц, дүнг баримтжуулах ёстой.

8. Халхавчилсан арга хэмжээг зогсоох шийдвэрийг ерөнхийдөө үүссэн нөхцөл байдал, баримтанд үндэслэж шийдвэрлэнэ.

Ийм шийдвэр гаргахдаа тодорхойлсон зорилтдоо хүрсэн эсэх, хүрэх боломжгүй байсан эсэх эсхүл харьцангуй үндэслэлгүй их хүч, хэрэгсэл, нөөц хөрөнгө шаардлагатай байгаа эсэх зэрэг асуудлыг харгалзан үзнэ. Объектыг буруутгах үндэслэл худал бол халхавчилсан арга хэмжээг зогсооно.

## ЦЭВЭР ӨРТӨГ ТООЦОХ АРГАТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

9. Цэвэр өртгийг тооцоолох зорилго нь татвар ноогдуулах эсхүл хууль бус орлогыг илрүүлэх явдал байдаг. Хөрөнгө болон өр төлбөр, өглөгийн хоорондох ялгааг тооцоолох нь цэвэр өртгийг тооцоолох аргын үндсэн зарчим юм. Цэвэр өртөгт орсон өөрчлөлт нь янз бүрийн хугацаанд цэвэр өртөгт орсон ялгаа байдаг. Тухайлбал, 1 жилийн дотор орсон өөрчлөлт. Цэвэр өртөг нь хөрөнгө худалдаж авах, худалдах, өр төлбөр, өглөг (үүрэг) хумигдах, нэмэгдэхийн үр дүнд өөрчлөгддөг. Үүний дараа тодорхой хугацаанд тухайн хүний зарцуулсан нийт хөрөнгийг тодорхойлохын тулд зарлагыг өөрчлөгдсөн аливаа цэвэр өртөг дээр нэмдэг.

10. Цэвэр өртгийн тооцоо (Хөрөнгө - Үүрэг = Цэвэр өртөг) нь нягтлан бодох бүртгэлийн тэнцэлтэй ижил төстэй (Хөрөнгө - Үүрэг = Өөрийн хөрөнгө)

11. Цэвэр өртгийг шууд бусаар тооцох нотолгооны арга нь хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг тодорхойлох хамгийн үр дүнтэй арга. Хууль бус орлогыг тооцолон гаргах дараах 3 үндсэн үе шат байдаг. Үүнд:

**12. Тухайн хүний хөрөнгийн цэвэр өртөгт орсон өөрчлөлтийг тооцох (өглөг, өр төлбөрөөс хасагдах хөрөнгө).** Цэвэр өртгийг тодорхой хугацааны эхэн ба төгсгөлийн үеийн байдлаар (татвар ноогдох жил эсхүл хэд хэдэн жил) тодорхойлж, эхэн үеийн цэвэр өртгийг төгсгөлийн хугацааны байдлаарх цэвэр өртгөөс хасах. Энэхүү гаргасан тооцоо нь хөрөнгийн цэвэр өртөгт орсон өөрчлөлт болох ба энэ нь түүний өсөлт эсхүл бууралтыг харуулдаг.

**13. Цэвэр өртгийн гаргасан тооцоонд тохируулга хийх.** Үүнд тухайн хувь хүний амьжиргааны зардал (зарлага), тодорхой

алдагдал болон хууль ёсны үүсвэрээс олсон орлогыг харгалзан үзэх шаардлагатай.

**14. Хууль бус эсхүл тайлбарлах боломжгүй орлогыг нийт олсон орлого болон бүртгэгдсэн буюу мэдэгдэж буй орлогын эх үүсвэртэй харьцуулах замаар тодорхойлдог.**

## САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

### САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БҮЛЭГ (FATF)

ФАТФ (2005) Олон улсын тэргүүн туршлага: Бэлэн мөнгө ба төлбөрийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар дамнан тээвэрлэхийг илрүүлэх урьдчилан сэргийлэх тухай (Тусгай зөвлөмж 9), ФАТФ, Парис, Франц.

[www.fatf-gafi.org/topics/fatfrecommendations/documents/bestpracticescashcourierssrix.html](http://www.fatf-gafi.org/topics/fatfrecommendations/documents/bestpracticescashcourierssrix.html)

Терроризмыг санхүүжүүлэх ФАТФ (2008).

[www.fatf-gafi.org/topics/methodsandtrends/documents/name.1599.en.html](http://www.fatf-gafi.org/topics/methodsandtrends/documents/name.1599.en.html)

Хөрөнгө хураах сайн туршлага (Зөвлөмж 3 ба 38). ФАТФ, Парис.

[www.fatf-gafi.org/topics/fatfrecommendations/documents/bestpracticesconfiscationrecommendations3\\_and38.html](http://www.fatf-gafi.org/topics/fatfrecommendations/documents/bestpracticesconfiscationrecommendations3_and38.html)

ФАТФ (2012), Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэхтэй тэмцэх тухай олон улсын стандарт. ФАТФ, Парис, Франц.

[www.fatf-gafi.org/topics/fatfrecommendations/documents/fatfrecommendations2012.html](http://www.fatf-gafi.org/topics/fatfrecommendations/documents/fatfrecommendations2012.html)

### ЕВРОПЫН ЗӨВЛӨЛ (COUNCIL OF EUROPE)

Голобинек Роберт. (2006), Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа ба гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураах: Хууль сахиулах байгууллага болон шүүхэд зориулсан гарын авлага, Европын Зөвлөл, Страсбург, Франц.

[www.coe.int/t/dghl/cooperation/economiccrime/SpecialFiles/CARPO-ManualFinInv\\_eng.pdf](http://www.coe.int/t/dghl/cooperation/economiccrime/SpecialFiles/CARPO-ManualFinInv_eng.pdf)

### ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА (OECD)

ЭЗХАХБ (2009), Татварын байцаагч болон татварын хянан шалгагч нарт зориулсан мөнгө угаах гэмт хэргийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх гарын авлага, Парис, Франц. [www.oecd.org/dataoecd/61/17/43841099.pdf](http://www.oecd.org/dataoecd/61/17/43841099.pdf)

ЭЗХАХБ (2009), Татварын байцаагч болон татварын хянан шалгагч нарт зориулсан авлигын гэмт хэргийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх гарын авлага. [www.oecd.org/dataoecd/20/20/37131825.pdf](http://www.oecd.org/dataoecd/20/20/37131825.pdf)

## ИХ БРИТАНИ (UNITED KINGDOM)

Цагдаагийн ахлах ажилтнуудын холбоо. Centrex (2006), Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны практик зөвлөмж [www.surreycc.gov.uk/data/assets/pdf\\_file/0007/171970/Advice-on-financial-investigation.pdf](http://www.surreycc.gov.uk/data/assets/pdf_file/0007/171970/Advice-on-financial-investigation.pdf)

Үндэсний Цагдаагийн Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Агентлаг, Лондон, Их Британи.

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны ур чадвар суулгах эрчимжүүлсэн курс (*Enhanced Financial Investigation Skills Course*)

Санхүүгийн тагнуулын ажилтны курс (*Financial Intelligence Officer course*)

Бэлэн мөнгө хураах курс (*Cash Seizure Course*)

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны курс (*Financial Investigation Course*)

Санхүүгийн мөрдөн байцаагч нарт зориулсан интернет орчинд судалгаа хийх курс (*Internet Research Skills for Financial Investigators*)

Гэмт хэргийн орлогын удирдлагын курс (*Proceeds of Crime Management Course*)

Хөрөнгө хураах курс (*Confiscation Course*)

Гэмт хэрэг нь өөрийгөө зөвтгөдөггүй - Гэмт хэргийн орлогыг илрүүлэх мэргэжилтэн бэлтгэх өндөр стандарт (*Making Sure Crime Doesn't Pay' Delivering excellence in Proceeds of Crime Training*)

## НҮБ-Н ХАР ТАМХИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГА (UNODC)

Прокурор, мөрдөн байцаагч нарт зориулсан авлигын эсрэг практик арга хэмжээ авах гарын авлага. Вена, Австри. [www.unodc.org/pdf/crime/corruption/Handbook.pdf](http://www.unodc.org/pdf/crime/corruption/Handbook.pdf)

## НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА

НҮБ (2002), НҮБ-н Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенци. Нью-Йорк, АНУ. (2002) [www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html](http://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html)

## АНУ

АНУ-н Дотоод Аюулгүй Байдлын Яам (хугацаагүй), *Мэдээлэл ухуулга сурталчилгааны гол санаачилга*, [www.ice.gov/cornerstone](http://www.ice.gov/cornerstone), 2012 оны 6 дугаар сарын 29-ний өдөр хянан тохиолдуулсан.

АНУ-н Хууль зүйн яам (хугацаагүй), *Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зөвлөмж*. [www.justice.gov/criminal/afmls/pubs/pdf/fininvguide.pdf](http://www.justice.gov/criminal/afmls/pubs/pdf/fininvguide.pdf), 2012 оны 6 дугаар сарын 29-ний өдөр хянан тохиолдуулсан.

АНУ-н Хууль зүйн яам (хугацаагүй), *Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны хяналтын жагсаалт*. [www.justice.gov/criminal/afmls/pubs/pdf/fininvguide.pdf](http://www.justice.gov/criminal/afmls/pubs/pdf/fininvguide.pdf), 2012 оны 6 дугаар сарын 29-ний өдөр хянан тохиолдуулсан.

АНУ-н Засгийн газрын аудитын алба. (1997), *Мөрдөн байцаагч нарт зориулсан Мэдээллийн эх сурвалжийн тухай зөвлөмж*. Вашингтон, АНУ. [www.gao.gov/special.pubs/soi/os97002.pdf](http://www.gao.gov/special.pubs/soi/os97002.pdf)

АНУ-н Олон Улсын Хөгжлийн Агентлаг. (2005) *Авлигын хэргийг мөрдөн шалгах, шүүхэд хянан шийдвэрлэх зөвлөмж*. Бьёорлингтон, Вермонт, АНУ. [http://pdf.usaid.gov/pdf\\_docs/PNADE146.pdf](http://pdf.usaid.gov/pdf_docs/PNADE146.pdf)


## ДЭЛХИЙН БАНК - НҮБ-Н ХАР ТАМХИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГА (STAR САНААЧИЛГА)

Бран Ж.П. нар (2011), Хөрөнгө нөхөн төлүүлэх гарын авлага: Практикийн ажилтанд зориулсан зөвлөмж. СТАР-н Санаачилга, Дэлхийн Банк ба НҮБ-н Хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага, Вашингтон, АНУ. [www1.worldbank.org/finance/star\\_site/documents/arhandbook/ar\\_handbook\\_final.pdf](http://www1.worldbank.org/finance/star_site/documents/arhandbook/ar_handbook_final.pdf)


- Стивенсон М. болон бусад. (2011), Хөрөнгө нөхөн төлүүлэх ажиллагаанд учирдаг саад, тотгор, бэрхшээл: Үндсэн саад бэрхшээлд хийсэн дүн шинжилгээ болон практик зөвлөмж. 2011 он. СТАР-н Санаачилга, Дэлхийн Банк ба НҮБ-н Хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага, Вашингтон, АНУ. [www1.worldbank.org/finance/star\\_site/documents/barriers/barriers\\_to\\_asset\\_recovery.pdf](http://www1.worldbank.org/finance/star_site/documents/barriers/barriers_to_asset_recovery.pdf)
- СТАР (2009), Хулгайлагдсан хөрөнгийг илрүүлэх нь: Хөрөнгө нөхөн төлүүлэх дэлхийн дэд бүтэцийг сонжихуй. СТАР-н Санаачилга, Дэлхийн Банк ба НҮБ-н Хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага, Вашингтон, АНУ. [www1.worldbank.org/finance/star\\_site/documents/global\\_architecture/GlobalArchitectureFinalwithCover.pdf](http://www1.worldbank.org/finance/star_site/documents/global_architecture/GlobalArchitectureFinalwithCover.pdf)
- Бурдеску Р. (2009), Хөрөнгө, орлогын мэдүүлэг: *Хэрэгсэл ба буулт*, СТАР-н Санаачилга, Дэлхийн Банк ба НҮБ-н Хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага, Вашингтон, АНУ. [www1.worldbank.org/finance/star\\_site/documents/income\\_assessts/ADIncomeasset.pdf](http://www1.worldbank.org/finance/star_site/documents/income_assessts/ADIncomeasset.pdf)
- Гринберг болон бусад (2009), Шүүхийн шийдвэргүй хөрөнгө царцаах тэргүүн туршлагын тухай зөвлөмж, СТАР-н Санаачилга, Дэлхийн Банк ба НҮБ-н Хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага, Вашингтон, АНУ. [www1.worldbank.org/finance/star\\_site/documents/non-conviction/NCBGuideFinalEBook.pdf](http://www1.worldbank.org/finance/star_site/documents/non-conviction/NCBGuideFinalEBook.pdf)
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага ба Олон Улсын Сэргээн босголт, хөгжлийн/Дэлхийн банк, (2011) Авлигатай тэмцэх, хөрөнгө нөхөн төлүүлэх үүргийн биелэлтэд хяналт тавих нь СТАР-н Санаачилга, Дэлхийн Банк ба НҮБ-н Хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага, Вашингтон, АНУ. [www1.worldbank.org/finance/star\\_site/documents/AccraReport/Report/Accra%20Commitments.pdf](http://www1.worldbank.org/finance/star_site/documents/AccraReport/Report/Accra%20Commitments.pdf)







ISBN-978-99978-0-698-7



9 789997 806987